$$\log_2 x \cdot \log_2 2x = \log_2 x \cdot (1 + \log_2 x) = 2$$

болно. $t = \log_2 x$ орлуулга хийвэл $t^2 + t - 2 = 0$ тэгшитгэлд шилжинэ. Эндээс $t_1 = 1$, $t_2 = -2$ тул

$$x_1 = 2^{t_1} = 2, x_2 = 2^{t_2} = 2^{-2} = 0.25$$

байна.

7.9.


$$\cos\left(\frac{\pi}{6} - \frac{\pi}{3}\right) = \cos\left(-\frac{\pi}{6}\right) = \frac{\sqrt{3}}{2}$$

тул $x = \frac{\pi}{6}$ нь шийд болно.

7.10.

$$\begin{aligned} \sqrt{3} \operatorname{tg}\left(3x + \frac{\pi}{4}\right) &= 1 \Leftrightarrow \operatorname{tg}\left(3x + \frac{\pi}{4}\right) = \frac{1}{\sqrt{3}} \Leftrightarrow \\ &\Leftrightarrow 3x + \frac{\pi}{4} = \operatorname{arctg} \frac{1}{\sqrt{3}} + \pi n = \frac{\pi}{6} + \pi n \\ &\Leftrightarrow 3x = -\frac{\pi}{12} + \pi n \Leftrightarrow x = -\frac{\pi}{36} + \frac{\pi n}{3} \end{aligned}$$

7.11. $\sin x > \frac{1}{2}$. Хэрэв x өнцгийг цагийн зүүний эсрэг чиглэлд байгуулвал нэгж тойрогтой огтлолцох цэгүүд нь $s = \frac{1}{2}$ шулуунаас дээш оршино. Эндээс $\frac{\pi}{6} < x < \frac{5\pi}{6}$ болно.



7.12.

$$\sqrt{2} \cos 8x + \sqrt{2} \sin 8x = -1 \Rightarrow \frac{\sqrt{2}}{2} \cos 8x + \frac{\sqrt{2}}{2} \sin 8x = -\frac{1}{2}$$

буюу

$$\sin\left(8x + \frac{\pi}{4}\right) = -\frac{1}{2} \Rightarrow 8x + \frac{\pi}{4} = (-1)^{k+1} \frac{\pi}{6} + \pi k \Rightarrow x = \frac{12k - 3 + 2 \cdot (-1)^{k+1}}{96} \pi$$

болно. $\frac{3\pi}{8} < x < \frac{7\pi}{10}$ нөхцлийг хангах шийдүүдийг олж.

$$\frac{3}{8} < \frac{12k - 3 + 2 \cdot (-1)^{k+1}}{96} < \frac{7}{10} \Rightarrow k = 4, 5, 6$$


болно. $k = 4$ үед $x_4 = \frac{43}{96}\pi$, $k = 6$ үед $x_6 = \frac{67}{96}\pi \Rightarrow \frac{x_4}{x_6} = \frac{43}{67}$.

7.13. $\cos^2 x - \sin^2 x = \sin x \Leftrightarrow 1 - 2\sin^2 x = \sin x$ ба $s = \sin x$ гэвэл

$$2s^2 + s - 1 = 0 \Rightarrow s_1 = -1, s_2 = \frac{1}{2}$$

болно. Иймд

$$\begin{cases} \sin x = -1 \\ \sin x = \frac{1}{2} \end{cases}$$



Эндээс $[-\pi; \pi]$ завсар дахь шийдүүд нь $-\frac{\pi}{2}, \frac{\pi}{6}, \frac{5\pi}{6}$ тул үржвэр нь

$$-\frac{\pi}{2} \cdot \frac{\pi}{6} \cdot \frac{5\pi}{6} = -\frac{5\pi^3}{72}$$

байна.

7.14. $c = \cos x$ гэвэл

$$2\cos^2 x + 5\cos x + 2 = 2c^2 + 5c + 2 = (2c + 1)(c + 2) \geq 0$$

болно. $\cos x + 2 > 0$ тул $2c + 1 \geq 0$ буюу $\cos x > -\frac{1}{2}$ болно. Тэнцэтгэл бишийн шийд нь

$$-\frac{\pi}{3} + 2\pi k < x < \frac{\pi}{3} + 2\pi k, k \in \mathbb{Z}$$

7.15.

$$\cos^2 4x + \sin^2 2x = 1 \Leftrightarrow \sin^2 2x = 4\sin^2 2x \cos^2 2x$$

тул $\sin 2x = 0$ эсвэл $\cos^2 2x = \frac{1}{4}$ байна. Эхний тэгшитгэлээс $x = \frac{\pi k}{2}$ шийд гарна.

$\cos 2x = \frac{1 + \cos 4x}{2}$ тул сүүлийн тэгшитгэл нь

$$\frac{1 + \cos 4x}{2} = \frac{1}{4} \Leftrightarrow \cos 4x = -\frac{1}{2} \Leftrightarrow$$

$$4x = \pm \frac{2\pi}{3} + 2\pi k \Leftrightarrow x = \pm \frac{\pi}{6} + \frac{\pi k}{2}$$

болно. Шийдүүдийг нэгтгээд эмхэтгэвэл $x = \frac{\pi k}{6}$ болно.

7.16.

$$\cos^2 x > \frac{3}{4} \Leftrightarrow \frac{1 + \cos 2x}{2} > \frac{3}{4} \Leftrightarrow \cos 2x > \frac{1}{2}$$

Иймд

$$-\frac{\pi}{3} + 2\pi k < 2x < \frac{\pi}{3} + 2\pi k$$

буюу

$$-\frac{\pi}{6} + \pi k < x < \frac{\pi}{6} + \pi k$$

байна. Зөв хариулт нь A буюу $]-\frac{\pi}{6} + \pi k; \frac{\pi}{6} + \pi k[$ байна.

7.17.

$$\sin^2 x + \cos^2 x = 1 \Rightarrow \sin^4 x + 2\sin^2 x \cos^2 x + \cos^4 x = 1$$

тул

$$\sin^4 x + \cos^4 x = 1 - 2\sin^2 x \cos^2 x = \frac{5}{8} \Leftrightarrow 4\sin^2 x \cos^2 x = \frac{3}{4}$$

$\sin 2x = 2\sin x \cos x$ тул

$$\sin^2 2x = \frac{1 - \cos 4x}{2} = \frac{3}{4} \Leftrightarrow \cos 4x = -\frac{1}{2}$$

болно. Иймд $4x = \pm \frac{2\pi}{3} + 2\pi k$ буюу $x = \pm \frac{\pi}{6} + \frac{\pi k}{2}$ болно. Эдгээрээс $k = 0$ үед $\pm \frac{\pi}{6}$, $k = 1$ үед $\pm \frac{\pi}{6} + \frac{\pi}{2}$, $k = 2$ үед $\pm \frac{5\pi}{6}$ гэсэн шийдүүд өгөгдсөн завсарт оршино.

7.18. $\sin \frac{x}{2} = 2 \sin \frac{x}{4} \cos \frac{x}{4}$ тул

$$7 \sin \frac{x}{4} \cos \frac{x}{4} = 2 \cos \frac{x}{2} \cos \frac{x}{4}$$

болно. Эндээс $\cos \frac{x}{4} = 0$ эсвэл $7 \sin \frac{x}{4} = 2 \cos \frac{x}{2}$ байна.

$\cos \frac{x}{4} = 0 \Rightarrow \frac{x}{4} = \frac{\pi}{2} + \pi k \Rightarrow x = 2\pi + 4\pi k$ тул $0 < x < 2\pi$ нөхцөлийг хангах шийдгүй.

$7 \sin \frac{x}{4} = 2 \cos \frac{x}{2}$ тэгшитгэлийн хувьд $s = \sin \frac{x}{4}$ гэвэл $\cos \frac{x}{2} = 1 - 2s^2$ тул $7s = 2 - 4s^2$.

Тэгшитгэлийг бодвол $s = \frac{1}{4}$ эсвэл $s = -2$ гэж гарах ба $|s| \leq 1$ тул $s = -2$ шийд биш. Иймд $\sin \frac{x}{4} = \frac{1}{4}$ байна.

7.19. 1-р бодолт. $x = \frac{\pi}{2}$ үед $\sin x = 1$, $\sin 2x = \sin \pi = 0$, $\cos x = 0$ тул

$$\sin \frac{\pi}{2} - 1 = \frac{1}{2} \sin \pi - \cos \frac{\pi}{2} \Leftrightarrow 1 - 1 = \frac{1}{2} \cdot 0 - 0$$

байна. Иймд $x = \frac{\pi}{2}$ шийд болж байна. 2-р бодолт.

$$\sin x - 1 = \frac{1}{2} \sin 2x - \cos x = \sin x \cos x - \cos x \Leftrightarrow$$

$$\sin x - 1 = (\sin x - 1) \cos x \Leftrightarrow (\sin x - 1)(\cos x - 1) = 0$$

тул $\sin x = 1$ эсвэл $\cos x = 1$ байна. Иймд $0 < x < \pi$ завсарт $x = \frac{\pi}{2}$ гэсэн ганцхан шийдтэй байна.

7.20.

$$\sin 2x + 5(\sin x + \cos x) + 1 = 0 \Leftrightarrow (\sin x + \cos x)^2 + 5(\sin x + \cos x) = 0$$

$$\Leftrightarrow (\sin x + \cos x + 5)(\sin x + \cos x) = 0$$

Эндээс $\sin x + \cos x + 5 > 0$ тул $\sin x + \cos x = 0$ буюу $\operatorname{tg} x = -1 \Leftrightarrow x = \frac{3\pi}{4} + \pi k$ болно. $k = -2$

үед $x = -\frac{5\pi}{4}$, $k = -1$ үед $x = -\frac{3\pi}{4}$, $k = 0$ үед $x = \frac{3\pi}{4}$ гэсэн 3 шийд $\left[-\frac{5\pi}{4}, \pi\right]$ завсарт оршино.

7.21.

$$t^2 - (1 + \sqrt{3})t + \sqrt{3} < 0 \Leftrightarrow 1 < t < \sqrt{3}$$

тул $1 < \operatorname{tg} x < \sqrt{3}$ болно. Иймд $\frac{\pi}{4} + \pi k < x < \frac{\pi}{3} + \pi k$ байна.

7.22. $\sin(7x - x) = \sin 7x \cos x - \cos 7x \sin x$ тул

$$\sin 7x \cos x = \sin 6x \Leftrightarrow \cos 7x \sin x = 0$$

болно.

$$\cos 7x = 0 \Leftrightarrow 7x = \frac{\pi}{2} + \pi n \Leftrightarrow x = \frac{\pi}{14} + \frac{\pi n}{7}$$

$$\sin x = 0 \Leftrightarrow x = \pi n$$

тул тэгшитгэлийн ерөнхий шийд нь $x_1 = \frac{\pi}{14} + \frac{\pi n}{7}$, $x_2 = \pi n$ байна.

7.23. $4\cos^2 x + \sin 2x = 1$ тэгшитгэлийг бодъё. Давхар өнцгийн синусын томьёо болон үндсэн адилтгал ашиглавал

$$4\cos^2 x + 2\sin x \cos x = \sin^2 x + \cos^2 x$$

тул

$$3\cos^2 x + 2\sin x \cos x - \sin^2 x = 0$$

болно. $\sin x \neq 0$ тул $\sin^2 x$ тоонд тэгшитгэлийн 2 талыг хувааж өгвөл

$$3\operatorname{ctg}^2 x + 2\operatorname{ctg} x - 1 = 0$$

тэгшитгэлд шилжинэ. Эндээс $\operatorname{ctg} x = -1$ эсвэл $\operatorname{ctg} x = \frac{1}{3}$ тул тэгшитгэлийн шийд нь

$$x = \frac{3\pi}{4} + \pi k, \quad x = \operatorname{arccctg} \frac{1}{3} + \pi k$$

7.24. $-1 \leq \sin x, \cos x \leq 1$ тул

$$4\sin^4 2x - 5\cos^3 4x \leq 4 \cdot 1^4 - 5 \cdot (-1)^3 = 9$$

ба тэнцэл зөвхөн $\sin 2x = 1$, $\cos 4x = -1$ үед биелэнэ.

$\sin 2x = 1 \Rightarrow 2x = \frac{\pi}{2} + 2\pi k$ буюу $x = \frac{\pi}{4} + \pi k$ ба $k = 0$ үед $x = \frac{\pi}{4}$ нь хамгийн бага эерэг шийд нь бөгөөд энэ үед $\cos 4 \cdot \frac{\pi}{4} = \cos \pi = -1$ тул анхны тэгшитгэлийн ч шийд болно. Иймд бидний олох хамгийн бага өнцөг нь 45° юм.

7.25. Үржвэр тус бүрийг нийлбэрт шилжүүлвэл:

$$\frac{1}{2} [\cos(7x + 6x) + \cos(6x - 7x)] = \frac{1}{2} [\cos(8x + 9x)x + \cos(8x - 9x)]$$

буюу $\cos 13x - \cos 17x = 0$ болно. Энэ ялгаварыг үржвэрт шилжүүлвэл

$$2 \cdot \sin \frac{13x + 17x}{2} \cdot \sin \frac{13x - 17x}{2} = 0$$

тул

$$\begin{cases} \sin 15x = 0 \\ \sin 2x = 0 \end{cases} \Rightarrow \begin{cases} x = \frac{k\pi}{15} \\ x = \frac{n\pi}{2} \end{cases} \quad (k, n \in \mathbb{Z})$$

8. Дараалал, Нийлбэр, Функц, Өгүүлбэртэй бодлого 2

8.1.

$$f(g(x)) = f(2x + 1) = (2x + 1)^2 + 1 = 4x^2 + 4x + 2$$

8.2. $f(x) = \frac{\operatorname{ctg} x}{\operatorname{tg} 2x + \sin 2x}$ функц нь

$$\begin{aligned} f(-x) &= \frac{\operatorname{ctg}(-x)}{\operatorname{tg}(-2x) + \sin(-2x)} \\ &= \frac{-\operatorname{ctg} x}{-\operatorname{tg} 2x - \sin 2x} \\ &= \frac{\operatorname{ctg} x}{\operatorname{tg} 2x + \sin 2x} = f(x) \end{aligned}$$

тул тэгш функц юм.

8.3. Логарифм ба арккосинус функцийг тодорхойлогдох мужаас $x > 0$ ба $-1 \leq \frac{x-3}{4} \leq 1$ тул $0 < x \leq 7$ ба бутархайн хуваарь тэгээс ялгаатай тул

$$\arccos \frac{x-3}{4} \neq 0 \Leftrightarrow \frac{x-3}{4} \neq 1 \Leftrightarrow x \neq 7$$

Иймд $0 < x < 7$ байна.

8.4. Гишүүд нь $x_1 = \frac{1}{2}$, $x_2 = \frac{1}{2 - \frac{1}{2}} = \frac{2}{3}$, $x_3 = \frac{1}{2 - \frac{2}{3}} = \frac{3}{4}$, $x_4 = \frac{1}{2 - \frac{3}{4}} = \frac{4}{5}$ тул $x_n = \frac{n}{n+1}$ байна.

8.5.

$$a_{900} - a_{100} = (900 - 100)d = -1801 - (-201) = -1600$$

тул $d = -2$ байна. Иймд

$$a_n - a_{100} = (n - 100) \cdot (-2) \Rightarrow a_n = a_{100} - 2n + 200$$

тул $a_n = -2n - 1$ байна.

8.6. $\sqrt[3]{7}$, $\sqrt[4]{7}$, 7 тоонууд геометр прогресс үүсгэх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь

$$\sqrt[3]{7} \cdot 7 = (\sqrt[4]{7})^2 \Leftrightarrow 7^{\frac{4}{3}} = 7^{\frac{2}{k}} \Leftrightarrow \frac{4}{3} = \frac{2}{k}$$

тул $k = \frac{3}{2}$ байна.

8.7. $S = \frac{b_1}{1-q} \Rightarrow 9 = \frac{3}{1-q}$ буюу $q = \frac{2}{3}$ байна. Иймд $b_2 = b_1 \cdot q = 3 \cdot \frac{2}{3} = 2$. $\square$

8.8. $999 = 102 + 3(n-1) \Rightarrow n = 300$ байна. $a_1 = 102$, $a_{300} = 999$ тул эхний 300 гишүүний нийлбэр нь

$$S_{300} = \frac{102 + 999}{2} \cdot 300 = 165150$$

байна.

8.9.

$$S_2 = b_1 + b_1 q = 7$$

$$\begin{aligned} S_6 &= b_1 + b_1 q + b_1 q^2 + b_1 q^3 + b_1 q^4 + b_1 q^5 \\ &= (b_1 + b_1 q)(1 + q^2 + q^4) = 7(1 + q^2 + q^4) = 91. \end{aligned}$$

Иймд $q^4 + q^2 - 12 = 0 \Rightarrow q^2 = -4 \vee 3$. $q^2 > 0$ тул $q^2 = 3$.

$$S_4 = b_1 + b_1 q + b_1 q^2 + b_1 q^3 = (b_1 + b_1 q)(1 + q^2) = 7 \cdot (1 + 3) = 28.$$

8.10. $b_5 = b_2 \cdot q^3$ тул $16 = 2 \cdot q^3 \Rightarrow q^3 = 8 \Rightarrow q = 2$ байна. $b_1 = \frac{b_2}{q} = \frac{2}{2} = 1$ тул

$$S_n = \frac{1 \cdot (2^n - 1)}{2 - 1} = 2^n - 1$$

8.11. $\sum_{m=1}^6 \sum_{n=1}^4 (mn) = \sum_{m=1}^6 (m \sum_{n=1}^4 n) = \sum_{m=1}^6 (m \cdot 10) = 10 \sum_{m=1}^6 m = 10 \cdot 21 = 210.$

8.12.

$$\sqrt[4]{x \sqrt[3]{4}} = \sqrt[3]{4} \Rightarrow x \sqrt[3]{4} = (\sqrt[3]{4})^4 \Rightarrow x = (\sqrt[3]{4})^3 = 4$$

байна.

8.13. $a_n = S_n - S_{n-1}$ байх тул

$$a_{2012} = 3^{2012} - 3^{2011} = 2 \cdot 3^{2011}$$

байна.

8.14.

$$\begin{aligned} \sum_{n=1}^8 \frac{1}{\sqrt{n} + \sqrt{n+1}} &= \frac{1}{1 + \sqrt{2}} + \frac{1}{\sqrt{2} + \sqrt{3}} + \cdots + \frac{1}{\sqrt{8} + \sqrt{9}} \\ &= (\sqrt{2} - \sqrt{1}) + (\sqrt{3} - \sqrt{2}) + \cdots + (\sqrt{9} - \sqrt{8}) \\ &= \sqrt{9} - \sqrt{1} = 3 - 1 = 2 \end{aligned}$$

8.15. Төмсний жинг 100% гэвэл байцааных 138%, луувангийх 60% ба нийт жин нь 298% болно. 298% нь 14.9 кг болно. 138% нь

$$\begin{array}{rcl} 298\% & - & 14.9 \text{ кг} \\ 138\% & - & x \text{ кг} \end{array}$$

пропорцийг бодвол $x = \frac{138\% \cdot 14.9}{298\%} = \frac{138 \cdot 14.9}{2 \cdot 149} = \frac{13.8}{2} = 6.9$ кг болно.

8.16. Сүүлийн өдрийн $1 - \frac{8}{9} = \frac{1}{9}$ хэсэг нь 6 км тул сүүлийн өдөр $6 \cdot 9 = 54$ км зам явсан. Энэ нь 2 дахь өдөр эхлэхэд үлдсэн замын хагасаас 3 км илүү байна. Иймд 2 дахь өдөр эхлэхэд $(54 - 3) \cdot 2 = 102$ км үлдсэн байжээ. Энэ нь нийт замын $\frac{2}{3}$ -оос 2 км илүү тул нийт замын $\frac{2}{3}$ нь $102 - 2 = 100$ км. Иймд нийт зам нь $100 \cdot \frac{3}{2} = 150$ км байжээ.

8.17. Заавраас харахад номын хуудасны тоо нь 3 оронтой тоо байх нь харагдаж байна. Түүнчлэн номын эхний 99 хуудсыг дугаарлахад 189 цифр шаардлагатай ба $100, 101, \dots, n$ хуудсыг дугаарлахад $3(n - 99)$ цифр шаардлагатай. Иймд

$$189 + 3(n - 99) = 756 \Rightarrow n = \frac{756 - 189 + 3 \cdot 99}{3} = 288$$

байна.

8.18. Гэрлийн шонгууд хоорондоо ижил m зайд байсан гэе. Хашааны нийт урт $(12 + 24 + 30 + 42 + 18) = 126$ тул $126/m$ гэрлийн шон хэрэгтэй. Хашааны булангуудад гэрэл байрлах тул тус бүр $\frac{12}{m} + 1, \frac{24}{m} + 1, \frac{30}{m} + 1, \frac{42}{m} + 1, \frac{18}{m} + 1$ шон байрлана. Иймд эдгээр нь бүхэл тоонууд байх ёстой бөгөөд энэ нөхцөлийг биелүүлж байхаар хамгийн их m тоог сонгох хэрэгтэй (энэ үед $126/m$ хамгийн бага байна). $m = \text{ХИЕХ}(12, 24, 30, 42, 18) = 6$ дээрх нөхцөлийг хангана. Энэ үед $126/6 = 21$ гэрлийн шон хэрэгтэй.

8.19. Б сургууль үлдсэний $\frac{5}{8}$ хэсгийг суулгасан тул В сургуулийн 195 мод нь үлдсэний $\frac{3}{8}$

байна. Иймд Б ба В сургууль нийтдээ $195 \cdot \frac{8}{3} = 520$ мод тарьсан. Энэ нь нийт модны

$1 - \frac{7}{20} = \frac{13}{20}$ хэсэг тул нийт $520 \cdot \frac{20}{13} = 800$ мод, үүнээс А сургууль $800 - 520 = 280$ мод тарьсан байна.

8.20.

$$\begin{cases} 2 \cdot \frac{1}{x} + 2 \cdot \frac{1}{y} = 1 \\ 2 \cdot \frac{1}{x} + \frac{1}{y} = \frac{5}{6} \end{cases}$$

байна. Эхний тэгшитгэлээс хоёр дахийг хасвал $\frac{1}{y} = \frac{1}{6} \Rightarrow y = 6$. Иймд $\frac{2}{x} + \frac{2}{6} = 1$. Эндээс $x = 3$ болов.

8.21.

	Хурд	Гүйцэх хүртэлх хугацаа	Гүйцэх хүртэлх зам	Үлдсэн хугацаа	Нийт зам
I хүн	v	$t + 1$	$v(t + 1)$	t	$v(2t + 1) = 18$
II хүн	$v + 3$	t	$(v + 3)t$	t	$2(v + 3)t$

2-р хүн t цаг яваад 1-р хүнийг гүйцсэн гэвэл 2-р хүн буцахдаа мөн t цаг явах учир нийт $2t$ цаг, 1-р хүн нийт $2t + 1$ цаг явна. Нэгдүгээр хүний хурдыг v км/цаг гэвэл

$$\begin{cases} v(2t + 1) = 18 \\ (v + 3)t = v(t + 1) \end{cases} \Rightarrow \begin{cases} v(2t + 1) = 18 \\ v = 3t \end{cases} \Rightarrow \begin{cases} 2t^2 + t = 6 \\ v = 3t \end{cases} \text{ байна. Тэгшитгэлийг бодвол} \\ t = 1.5 \text{ цаг, } v = 4.5 \text{ км/цаг байна.}$$

8.22. Урсгал дагуу 45 км замыг $\frac{45}{v+2}$ цагт, урсгал сөрж 22 км замыг $\frac{22}{v-2}$ цагт туулах тул

$$\frac{45}{v+2} + \frac{22}{v-2} = 5 \Rightarrow 45(v-2) + 22(v+2) = 5v^2 - 20$$

болно. Эндээс

$$5v^2 - 67v + 26 = 0$$

болох тул

$$v_{1,2} = \frac{67 \pm \sqrt{67^2 - 4 \cdot 5 \cdot 26}}{2 \cdot 5} = \frac{67 \pm 63}{10}$$

ба $v_2 = \frac{4}{10} < 2$ үед урсгал сөрж явах боломжгүй тул шийд биш. Иймд $v = v_1 = 13$ байна.

$$8.23. \frac{18 \cdot 20\% + x \cdot 26\%}{18 + x} = 20\% + 4\% = 24\% \text{ тэгшитгэлээс}$$

$$18 \cdot 20 + 26x = 18 \cdot 24 + 24x \Rightarrow 2x = 18 \cdot 4 \Rightarrow x = 36$$

байна.

8.24. Охидын тоог n гэвэл хөвгүүдийн тоо $2n$, ангийн нийт сурагчдын тоо $3n$ байна. Хөвгүүдийн авсан нийт оноо $2n \cdot 82\%$, охидын авсан нийт оноо $n \cdot 85\%$, харин ангийн нийт сурагчдынх $2n \cdot 82\% + n \cdot 85\% = n \cdot 249\%$ байна. Иймд дундаж оноо нь $\frac{n \cdot 249\%}{3n} = 83\%$ байна.

8.25. Нийт хэсгийг 1 гэвэл 1 минутад I хоолой бассейны $\frac{1}{t_1}$ хэсгийг, II хоолой $\frac{1}{t_2}$ хэсгийг дүүргэнэ. Иймд

$$\begin{cases} \frac{10}{t_1} + \frac{20}{t_2} = 1 \\ \frac{t_1}{5} + \frac{t_2}{15} = \frac{3}{5} \end{cases}$$

Иймд $\frac{10}{t_2} = 2 \cdot \frac{3}{5} - 1 = \frac{1}{5} \Rightarrow t_2 = 50$ болох тул

$$\frac{10}{t_1} = 1 - \frac{20}{50} \Rightarrow t_1 = \frac{50}{3}$$

байна.

9. Функци, Уламжлал, Интеграл 2

9.1. Зурагт өгсөн график нь параболын сөрөг утга авах мужийг OX тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргасан байгаа тул $y = |f(x)|$ хэлбэртэй буюу $y = |x^2 + x - 2|$ байна.

9.2. $x_0 = -\frac{4}{2 \cdot 1} = -2$ цэг дээр минимум утгаа авах тул хамгийн бага утга нь

$$(-2)^2 + 4 \cdot (-2) + a + 5 = 6$$

байна. Эндээс $a = 5$ байна.

9.3.

$$f'(x) = 20 \cdot (3x+1)^{19} \cdot (3x+1)' = 60(3x+1)^{19}$$

$$f'(1) = 60 \cdot (3 \cdot 1 + 1)^{19} = 15 \cdot 4^{20}$$

9.4.

$$\begin{aligned} y' &= ((x-3)^2)'(x+2)^3 + (x-3)^2((x+2)^3)' \\ &= 2(x-3)^{2-1}(x+2)^3 + (x-3)^2 \cdot 3(x+2)^{3-1} \\ &= 2(x-3)(x+2)^3 + 3(x-3)^2(x+2)^2 \end{aligned}$$


0 цэг дээр уламжлал нь

$$2(0-3)(0+2)^3 + 3(0-3)^2(0+2)^2 = -48 + 108 = 60$$

9.5. $y = \cos^2 \frac{\pi}{4}$ нь x -ээс үл хамааран тогтмол функц байна. Иймд $y' = 0$ байна.

9.6. $\operatorname{tg} 30^\circ = \frac{\sqrt{3}}{3} = \frac{1}{\sqrt{3}}$ тул налалт нь $\frac{1}{\sqrt{3}}$ байна.

9.7.




$f'(x) = 2x + 3$ ба $f(-1) = (-1)^2 + 3 \cdot (-1) = -2$, $f'(-1) = 2 \cdot (-1) + 3 = 1$ байна. Иймд функцийн графикийн $(-1, -2)$ цэгт татсан шүргэгч шулууны тэгшитгэл нь

$$y - (-2) = 1 \cdot (x - (-1)) \Rightarrow y = x - 1$$

байна.

9.8.



Шүргэгчдийн тэгшитгэл нь $y = -2x - 1$, $y = 6x - 9$ тул огтлолцлын цэг нь $(1, -3)$ байна.

9.9. $\forall x: f'(x) = 3x^2 + 6px + 12 > 0 \Leftrightarrow D = 36p^2 - 144 < 0 \Leftrightarrow -2 < p < 2$ байна.

9.10.

$$\left(\frac{1}{9-x^2}\right)^2 = \frac{1' \cdot (9-x^2) - 1 \cdot (9-x^2)'}{(9-x^2)^2} = \frac{2x}{(9-x^2)^2} < 0$$

$$\Leftrightarrow \begin{cases} 2x < 0 \\ 9-x^2 \neq 0 \end{cases} \Leftrightarrow x \in]-\infty; -3[\cup]-3; 0[$$

9.11.

$$f'(x) = (8x - 4x^{-2})' = 8 - (-2) \cdot 4x^{-2-1} = 8 + \frac{8}{x^3}$$

байна. $f'(x) = 8 + \frac{8}{x^3} = 0$ тэгшитгэлийг бодож сэжигтэй цэгийг олбол $x = -1$ байна.

$x < -1$ үед $f'(x) > 0$ тул өсч, $-1 < x < 0$ үед $f'(x) < 0$ тул буурна. Иймд $x = -1$ нь максимумын цэг байна.

9.12. $t = 3^x$ гэвэл $x \leq 1$ тул $0 < t \leq 3^1 = 3$ байна. Энэ үед

$$f(x) = (3^x)^3 - 27 \cdot 3^x + 54 = t^3 - 27t + 54$$

болох тул $g(t) = t^3 - 27t + 54$ функцийн $0 < t \leq 3$ үеийн хамгийн бага утга нь бидний олох утга болно.

$$g'(t) = 3t^2 - 27$$

ба $0 < t \leq 3$ үед $g'(t) \leq 0$ тул буурах функц байна. Иймд хамгийн бага утгаа аргументийн хамгийн их утга буюу $t = 3$ үед авна. Иймд

$$f_{\min} = g_{\min} = g(3) = 3^3 - 27 \cdot 3 + 54 = 0$$

байна.

9.13.

x	$x < 2$	$x = 2$	$2 < x < 5$	$x = 5$	$5 < x$
$f'(x)$	-	0	+	0	-
$f(x)$	$\searrow$	минимум	$\nearrow$	максимум	$\searrow$

Хүснэгтээс харахад $f'(x)$ нь $x < 2$ үед сөрөг, $2 < x < 5$ үед эерэг, $5 < x$ үед сөрөг байх тул $f(x)$ нь $x < 2$ үед буурч, $2 < x < 5$ үед өсөж, $5 < x$ үед буурна. Иймд 1-р өгүүлбэр үргэлж үнэн.

2-р өгүүлбэр үргэлж үнэн байх албагүй. Хэдийгээр $f(x)$ нь $x = 5$ үед локаль максимум утга мөн боловч $x < 2$ үед $f(1) > f(5)$ байх боломжтой.

3-р өгүүлбэр үргэлж үнэн байна. Учир нь $x < 2$ үед $f(x)$ буурах тул $[1; 2]$ завсрын хамгийн бага утга нь $f(2)$, $2 < x < 5$ завсарт өсөх тул $[2; 5]$ завсрын хамгийн бага утга нь мөн л $f(2)$ байна. Иймд $f(2)$ нь $[1; 5]$ завсрын хамгийн бага утга байна.

9.14. $x'(t) = 3t^2 - 8t$, $x''(t) = 6t - 8$ тул $x''(3) = 6 \cdot 3 - 8 = 10$.9.15. $\int \cos 3x \, dx = \frac{\sin 3x}{3} + C$ байна.

9.16.

$$\int \frac{\sqrt[3]{x^2} - 2}{\sqrt[3]{x}} \, dx = \int x^{\frac{1}{3}} \, dx - 2 \int x^{-\frac{1}{3}} \, dx =$$

$$= \frac{x^{\frac{1}{3}+1}}{\frac{1}{3}+1} - 2 \cdot \frac{x^{-\frac{1}{3}+1}}{-\frac{1}{3}+1} + C = \frac{3}{4} \sqrt[3]{x^4} - 3 \sqrt[3]{x^2} + C$$

9.17.

$$\int e^{-x} dx = \frac{e^{-x}}{-1} + C = -e^{-x} + C$$

9.18.

$$\begin{aligned} \int_1^2 \frac{2x^3+1}{x^2} dx &= \int_1^2 2x + \frac{1}{x^2} dx = \left(x^2 - \frac{1}{x} \right) \Big|_1^2 \\ &= \left(2^2 - \frac{1}{2} \right) - \left(1^2 - \frac{1}{1} \right) = 3.5 \end{aligned}$$

9.19. $f(x) = \frac{5}{3+5x}$, $g(x) = e^x$ гээд оруулгын аргаар бодвол

$$\int f(x) dx = \int \frac{5}{3+5x} dx = \ln(3+5x) + C$$

ба $g'(x) = e^x$ тул

$$\begin{aligned} \int_0^{\ln 3} f[g(x)]g'(x) dx &= \int_0^{\ln 3} \frac{5}{3+e^x} \cdot e^x dx = \int_0^{\ln 3} \frac{5}{3+e^x} de^x \\ &= \int_{e^0}^{e^{\ln 3}} \frac{5}{3+t} dt = \int_1^3 \frac{5}{3+t} dt \\ &= \ln(3+5 \cdot 3) - \ln(3+5 \cdot 1) = \ln \frac{9}{4} \end{aligned}$$

9.20.

$$\begin{aligned} \int_0^3 |1-x^2| dx &= \int_0^1 (1-x^2) dx + \int_1^3 (x^2-1) dx \\ &= \left(x - \frac{x^3}{3} \right) \Big|_0^1 + \left(\frac{x^3}{3} - x \right) \Big|_1^3 \\ &= \left(1 - \frac{1}{3} \right) - 0 + (9-3) - \left(\frac{1}{3} - 1 \right) = \frac{22}{3} \end{aligned}$$


9.21.

$$\left(\int_0^x \cos 3t dt \right)' = \cos 3x$$

9.22. $x+y=2 \Rightarrow y=2-x$. Үүнийг $y=x^2$ -д оруулж бодвол $x^2+x-2=0$ тэгшитгэлээс $\alpha=-2$, $\beta=1$ байна. Иймд зааварт өгсөн томьёо ёсоор

$$\int_{-2}^1 (x+2)(x-1) dx = \frac{(1-(-2))^3}{6} = \frac{9}{2} = 4.5$$

9.23. $f(x) = 2x^2$, $g(x) = 0$ гээд $\alpha = -1$, $\beta = 1$ гээд талбайг олбол $\int_{-1}^1 2x^2 dx$ болох ба энэ интегралаар илэрхийлэгдэх талбай нь 4) байна.



Жич: 1) дүрсийн талбай нь $\int_{-1}^1 (2 - 2x^2) dx$; 2) дүрсийн талбай нь $\int_0^1 2x^2 dx$; 3) дүрсийн талбай нь $\int_{-1}^1 (2 - 2x^2) dx$, 5) дүрсийн талбай нь $\int_{-1}^1 2 dx$ байна.

9.24.


$$f'(x) = (x + 8x^{-2})' = 1 - \frac{16}{x^3}$$

байна. $x \in [-2; -1]$ үед $f'(x) \geq 1 - \frac{16}{(-2)^3} > 0$ тул $f(x)$ функц $[-2, -1]$ мужид өснө. Иймд

$f(x)$ функцийн хамгийн их утга нь $f(-1) = -1 + \frac{8}{(-1)^2} = 7$, хамгийн бага утга нь

$f(-2) = -2 + \frac{8}{(-2)^2} = 0$ ба нийлбэр нь $7 + 0 = 7$ байна.

9.25.



ℓ_1 ба ℓ_2 -ын огтлолын цэгт $x^2 = \sqrt{x}$ тул $x = 0$, $x = 1 \Rightarrow x = 1$, $y = 1$ байна.


$$1. V_1 = \pi \int_0^1 (x^2)^2 dx = \pi \frac{x^5}{5} \Big|_0^1 = \frac{\pi}{5}.$$

$$2. V_2 = \pi \int_0^1 (\sqrt{x})^2 dx = \pi \frac{x^2}{2} \Big|_0^1 = \frac{\pi}{2}.$$

$$3. V_3 = V_2 - V_1 = \frac{3}{10} \pi.$$

10. Алгебр сэдвийн давтлага 2

10.1.



зургаас харахад $f(x)$ функцийн график I, II, III мужид зурагдсан байна.

10.2. 1-р бодолт.

$$\left| \frac{3 \cdot (-3) - 4}{3 - (-3)} \right| = \frac{13}{6} > 2, \quad \left| \frac{3 \cdot (-2) - 4}{3 - (-2)} \right| = 2 \leq 2, \quad \left| \frac{3 \cdot 0 - 4}{3 - 0} \right| = \frac{4}{3} < 2,$$

$$\left| \frac{3 \cdot 2 - 4}{3 - 2} \right| = 2 \leq 2, \quad \left| \frac{3 \cdot 3 - 4}{3 - 3} \right| = \text{утгагүй}$$

тул $-3, 3$ шийд болохгүй бусад нь шийд болж байна. Иймд $-2, 0, 2$ -ийг агуулсан $-3, 3$ агуулаагүй хариулт буюу $-2 \leq x \leq 2$ нь зөв хариулт байна. 2-р бодолт. Тэнцэтгэл биш нь

$$\begin{cases} -2 \leq \frac{3x-4}{3-x} \\ \frac{3x-4}{3-x} \leq 2 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} \frac{3x-4}{3-x} + \frac{2(3-x)}{3-x} \geq 0 \\ \frac{3x-4}{3-x} - \frac{2(3-x)}{3-x} \leq 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} \frac{3x-4}{3-x} + \frac{2(3-x)}{3-x} \geq 0 \\ \frac{3x-4}{3-x} - \frac{2(3-x)}{3-x} \leq 0 \end{cases}$$

буюу

$$\begin{cases} \frac{3x-4+2(3-x)}{3-x} \geq 0 \\ \frac{3x-4-2(3-x)}{3-x} \leq 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} \frac{x+2}{x-3} \leq 0 \\ \frac{x-3}{x-3} \geq 0 \end{cases}$$

болно. Эхний тэнцэтгэл бишийн шийд нь $[-2; 3]$, хоёр дахь тэнцэтгэл бишийн шийд нь $] -\infty; 2] \cup] 3; +\infty[$ ба огтлолцол нь $[-2; 2]$ буюу $-2 \leq x \leq 2$ байна.

10.3. 1-р бодолт. $x = -1$ нь

$$\begin{aligned} 4 \cdot 16^{-1} + 5 \cdot 12^{-1} &= \frac{4}{16} + \frac{5}{12} = \frac{3}{12} + \frac{5}{12} \\ &= \frac{8}{12} = \frac{2}{3} = 6 \cdot 9^{-1} \end{aligned}$$

тул шийд болно. Иймд $-1, \pm 1$ гэсэн сонголтууд үлдэж байна. $x = 1$ нь

$$4 \cdot 16 + 5 \cdot 12 = 64 + 60 = 124 \neq 6 \cdot 9$$

тул шийд болохгүй. Иймд зөв хариулт нь -1 буюу А сонголт байна. 2-р бодолт. Тэгшитгэлийг 9^x -д хуваавал

$$4 \cdot \left(\frac{4}{3}\right)^{2x} + 5 \cdot \left(\frac{4}{3}\right) - 6 = 0$$

болно. $t = \left(\frac{4}{3}\right)^x$ гэвэл

$$4t^2 + 5t - 6 = 0 \Leftrightarrow t_1 = \frac{3}{4}, t_2 = -2$$

болно. $t > 0$ тул $t = \frac{3}{4}$ нь шийд болно. Эндээс $\left(\frac{4}{3}\right)^x = \frac{3}{4}$ тул $x = -1$ байна.

10.4. 1-р бодолт. А хариултын хувьд нийт давсны хэмжээ нь $10 \cdot \frac{0.5}{100} + 20 \cdot \frac{2}{100}$ тул

концентраци нь $\frac{10 \cdot \frac{0.5}{100} + 20 \cdot \frac{2}{100}}{30} \cdot 100\% = \frac{5 + 40}{30} \% = 1.5\%$ тул зөв хариу болж байна. 2-р бодолт.

$$\frac{0.5\% + 2\% \cdot \alpha}{1 + \alpha} = 1.5\% \Leftrightarrow 0.5 + 2\alpha = 1.5 + 1.5\alpha$$

буюу $\alpha = 2$ байна. Иймд 1 : 2 хэмжээгээр нийт 30 л уусмал гаргаж авах тул 10; 20 л-ийг тус тус холино.

10.5. 1-р бодолт. $x = 1\frac{1}{3}$, $x = 28$ тоонууд тэнцэтгэл бишийн шийд, $x = 10$ шийд биш тул зөвхөн $(1; 4] \cup [28; +\infty)$ хариу зөв байна. 2-р бодолт. $t = \log_{\frac{1}{3}}(x - 1)$ гэвэл

$$t^2 + 3 \geq -4t \Leftrightarrow t^2 + 4t + 3 = (t + 3)(t + 1) \geq 0$$

болно. Иймд $t \leq -3 \vee t \geq -1$ болох тул $x > 1$ үед

$$\begin{cases} \log_{\frac{1}{3}}(x - 1) \leq -3 \\ \log_{\frac{1}{3}}(x - 1) \geq -1 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} x - 1 \geq \left(\frac{1}{3}\right)^{-3} \\ x - 1 \leq \left(\frac{1}{3}\right)^{-1} \end{cases} \Leftrightarrow \begin{cases} x \geq 27 \\ x \leq 4 \end{cases}$$

болно. Иймд тэнцэтгэл бишийн шийд нь $(1; 4] \cup [28; +\infty)$ байна.

10.6. Тодорхойлогдох муж нь $2x - 3 \geq 0 \Leftrightarrow x \geq \frac{3}{2}$ байна. Үржвэр тэгтэй тэнцэхийн тулд ядаж нэг үржигдэхүүн нь 0-тэй тэнцүү тул

$$x^2 - 4 = 0 \vee \sqrt{2x - 3} = 0 \Rightarrow x = \pm 2, x = \frac{3}{2}$$

байна. Гэвч $x = -2$ нь тодорхойлогдох мужид орохгүй тул шийд болж чадахгүй.

10.7. $2\sin^2 x > \sin 2x \Leftrightarrow \sin^2 x > \sin x \cos x \Leftrightarrow \sin x \cdot (\sin x - \cos x) > 0$. Иймд

$$\begin{cases} \sin x > 0 \\ \sin x > \cos x \end{cases} \cup \begin{cases} \sin x < 0 \\ \sin x < \cos x \end{cases} \text{ байна. Эхний тэнцэтгэл бишийн шийд нь } x \in \left[\frac{\pi}{2}; \pi\right]$$

байна. Хоёр дахь тэнцэтгэл бишийн шийд нь $x \in \left[\frac{5\pi}{4}; \frac{3\pi}{2}\right]$.

10.8. $a = \sqrt[4]{x+8}$, $b = \sqrt[4]{8-x}$ гэвэл $a^4 + b^4 = 16$, $a - b = 2$ тул

$$a^4 + (a - 2)^4 = 16 \Leftrightarrow 2a^4 - 8a^3 + 24a^2 - 32a = 0$$

болно. Энэ тэгшитгэл $a = 0$, $a = 2$ гэсэн хялбар шийдүүдтэй тул

$$2a(a - 2)(a^2 - 2a + 8) = 0$$

болж задарна. $D = (-2)^2 - 4 \cdot 1 \cdot 8 < 0$ тул $a^2 - 2a + 8 \neq 0$, $a = 0$ үед $b = \sqrt[4]{8-x} = -2$ болоход хүрэх тул зөвхөн $a = 2$ үед анхны тэгшитгэл шийдтэй байна. Иймд $\sqrt[4]{x+8} = 2 \Rightarrow x = 8$ ба шийд болохыг нь шалгах төвөгтэй биш юм.

10.9. $x - 2 = \sqrt{3} \Rightarrow (x - 2)^2 = 3$ буюу $x^2 - 4x + 1 = 0$.

10.10. 1-р бодолт. $x = 2$ нь шийд биш юм. Учир нь

$$\sqrt{2+3} + \sqrt{2-2} < \sqrt{4 \cdot 2 + 1} \Leftrightarrow \sqrt{5} < 3$$

Иймд 2-ийг агуулаагүй E нь зөв сонголт юм. 2-р бодолт. Тодорхойлогдох муж нь

$$\begin{cases} x+3 \geq 0 \\ x-2 \geq 0 \\ 4x+1 \geq 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} x \geq -3 \\ x \geq 2 \\ x \geq \frac{1}{4} \end{cases} \Leftrightarrow x \geq 2$$

байна.

Тодорхойлогдох муждаа тэнцэтгэл бишийн хоёр тал хоёулаа сөрөг биш тул

$$\begin{aligned} \sqrt{x+3} + \sqrt{x-2} &> \sqrt{4x+1} \Leftrightarrow \\ (\sqrt{x+3} + \sqrt{x-2})^2 &> (\sqrt{4x+1})^2 \Leftrightarrow \\ x+3 + 2\sqrt{x+3}\sqrt{x-2} + x-2 &> 4x+1 \Leftrightarrow \\ \sqrt{x+3} \cdot \sqrt{x-2} &> x \end{aligned}$$

болно.

Тодорхойлогдох муж нь $x \geq 2$ тул

$$\begin{aligned} \sqrt{x+3} \cdot \sqrt{x-2} > x &\Leftrightarrow (\sqrt{x+3} \cdot \sqrt{x-2})^2 > x^2 \Leftrightarrow \\ (x+3)(x-2) > x^2 &\Leftrightarrow x-6 > 0 \end{aligned}$$

10.11. $x^2 - 3x + 2 = (x-1)(x-2)$ тул

$$P(x) = (x-1)(x-2) \cdot Q(x) + ax + b, R(x) = ax + b \cdots (1)$$

болно. $P(x)$ -г $(x-1)$ -д хуваахад 1 үлдэх тул $P(1) = a + b = 1$. Нөгөө талаас

$$x^2 - x - 2 = (x+1)(x-2)$$

тул

$$P(x) = (x+1)(x-2) \cdot K(x) + 3x + 7$$

байна. $P(2) = 3 \cdot 2 + 7 = 13$ болох ба $x = 2$ -ийг (1)-д орлуулбал $P(2) = 2a + b = 13$. Эндээс a , b -г олж.

$$\begin{cases} a+b=1 \\ 2a+b=13 \end{cases}$$

Системийг бодож шийдийг олбол $a = 12$, $b = -11$ тул $R(x) = 12x - 11$ байна.

10.12. ХБЕХ(10, 26, 5) = 130 тул нийт сурагчдын тоо 130-д хуваагддаг байх ёстой. Иймд 130 k сурагч байсан гэе. Тэгвэл $130k \cdot \frac{1}{10} = 13k$ нь онц, $130k \cdot \frac{5}{26} = 25k$ нь сайн, $130k \cdot \frac{3}{5} = 78k$ нь дунд сурсан байна. Иймд хангалтгүй сурсан

$$130k - 13k - 25k - 78k = 14k$$

сурагч байна. Бид боломжит хамгийн цөөнийг нь сонирхож буй тул $k = 1$ үед 14 сурагч хангалтгүй дүн авна.

10.13.

$$(\sqrt{x}+1)(\sqrt[3]{x}-1) = (x^{\frac{1}{2}}+1)(x^{\frac{1}{3}}-1) = x^{\frac{5}{6}} - x^{\frac{1}{2}} + x^{\frac{1}{3}} - 1$$


тул

$$\begin{aligned} \int (\sqrt{x}+1)(\sqrt[3]{x}-1) dx &= \frac{x^{\frac{5}{6}+1}}{\frac{5}{6}+1} - \frac{x^{\frac{1}{2}+1}}{\frac{1}{2}+1} + \frac{x^{\frac{1}{3}+1}}{\frac{1}{3}+1} - x + C = \\ &= \frac{6x^{\frac{11}{6}}}{11} - \frac{2x^{\frac{3}{2}}}{3} + \frac{3x^{\frac{4}{3}}}{4} - x + C \end{aligned}$$

10.14. $1+x \neq 0$ буюу $x \neq -1$ үед

$$\frac{(x-2)(x+3)}{1+x} \geq 0 \Leftrightarrow (x+3)(x+1)(x-2) \geq 0$$

ба



тул $x \in [-3; -1] \cup [2; +\infty[$

10.15. 1 оронтой 9 тоо, 2 оронтой 90 тоо, 3 оронтой 271 тоо байгаа тул нийт

$$9 \cdot 1 + 90 \cdot 2 + 271 \cdot 3 = 1002$$

цифр ашиглана.

10.16. 1-р бодолт. $x < -\frac{2}{3}$ мужид $2x+1 < 0$, $3x+2 < 0$ тул $|2x+1| = -(2x+1)$, $|3x+2| = -(3x+2)$ болно. Иймд

$$|2x+1| + |3x+2| = -2x-1-3x-2 \leq 5x+3$$

тул

$$-5x-3 \leq 5x+3 \Leftrightarrow -6 \leq 10x \Leftrightarrow -\frac{3}{5} \leq x$$

болно. Эндээс $-\frac{3}{5} \leq x < -\frac{2}{3} \Rightarrow -\frac{3}{5} < -\frac{2}{3}$ болж зөрчил үүсч байна. Иймд $x < -\frac{2}{3}$ мужид тэнцэтгэл биш шийдгүй.

$-\frac{2}{3} \leq x < -\frac{1}{2}$ мужид $2x+1 < 0$, $3x+2 \geq 0$ тул $|2x+1| = -(2x+1)$, $|3x+2| = 3x+2$ болно. Иймд

$$|2x+1| + |3x+2| = -2x-1+3x+2 \leq 5x+3$$

тул

$$x+1 \leq 5x+3 \Leftrightarrow -2 \leq 4x \Leftrightarrow -\frac{1}{2} \leq x$$

болно. Эндээс $-\frac{1}{2} \leq x < -\frac{1}{2} \Rightarrow -\frac{1}{2} < -\frac{1}{2}$ болж зөрчил үүсч байна. Иймд $-\frac{2}{3} \leq x < -\frac{1}{2}$ мужид тэнцэтгэл биш мөн л шийдгүй.

$-\frac{1}{2} \leq x$ мужид $2x+1 \geq 0$, $3x+2 \geq 0$ тул $|2x+1| = 2x+1$, $|3x+2| = 3x+2$ болно. Иймд

$$|2x+1| + |3x+2| = 2x+1 + 3x+2 \leq 5x+3$$

тул

$$5x+3 \leq 5x+3$$

болох ба энэ тэнцэтгэл биш нь дурын x тооны хувьд биелэх тул $-\frac{1}{2} \leq x$ муж бүхлээрээ шийд болно.

Шийдүүдээ нэгтгэвэл бодлогын шийд $[-\frac{1}{2}; +\infty[$ болно. 2-р бодолт. $x = -0.75$ нь $|-1.5+1| + |-2.25+2| = 0.75 > -3.85+3 = -0.85$ тул шийд болохгүй. $x = -0.5$ нь $|-1+1| + |-1.5+1| = 0.5 \leq -2.5+3 = 0.5$ тул шийд болно. $x = 0$ нь $|0+1| + |0+2| = 3 \leq 0+3 = 3$ тул мөн шийд болно. Хариултууд дотроос -0.75 ороогүй, $-0.5, 0$ орсон муж нь зөвхөн $[-\frac{1}{2}; +\infty[$ тул зөв хариулт болно.

10.17. $t = \frac{x-2y}{5x+2y}$ гэвэл $\frac{1}{t} = \frac{5x+2y}{x-2y}$ тул $t + \frac{1}{t} = 2 \Leftrightarrow t = 1$ байна. Иймд

$$\frac{x-2y}{5x+2y} = 1$$

$x - y = 8$ -аас $y = x - 8$ тул

$$\frac{x-2y}{5x+2y} = \frac{x-2(x-8)}{5x+2(x-8)} = 1$$

Иймд $16 - x = 7x - 16 \Rightarrow x = 4$, $y = 4 - 8 = -4$ болох тул $x \cdot y = 4 \cdot (-4) = -16$ байна.

10.18. $f'(x) = 2x - 3$ тул $f(1) = 1^2 - 3 \cdot 1 = -2$, $f'(1) = 2 \cdot 1 - 3 = -1$. Иймд

$$y - (-2) = -1 \cdot (x - 1)$$

буюу $y = -x - 1$ байна.

10.19.

$$\frac{x^2 - 2y(3x - 5y)}{-xy + 3y^2} = 2 \Rightarrow x^2 - 6xy + 10y^2 = -2xy + 6y^2 \Rightarrow$$

$$x^2 - 6xy + 10y^2 + 2xy - 6y^2 = x^2 - 4xy + 4y^2 = (x - 2y)^2 = 0$$

тул $x = 2y$ байна. Иймд

$$\frac{x^3 + 2xy^2 - 3x^2y + 6y^3}{x^3 - 2y^3} = \frac{(2y)^3 + 2(2y)y^2 - 3(2y)^2y + 6y^3}{(2y)^3 - 2y^3} = \frac{6y^2}{6y^2} = 1$$

10.20. Хоёр автобус 1 цагт хамтдаа

$$\frac{1}{10} + \frac{1}{8} = \frac{9}{40}$$

хэсгийг туулах тул 4 цагт $4 \cdot \frac{9}{40} = \frac{9}{10}$ хэсгийг туулна. Иймд үлдэх зам нь нийт замын $\frac{1}{10}$ хэсэг тул нийт зам нь $40 \cdot 10 = 400$ км зайтай байжээ.

10.21. $x < -2$ үед $|2x+4| = -2x-4$, $|x-1| = -x+1$ тул

$$-2x-4 - x+1 = 10 \Leftrightarrow -3x = 13 \Rightarrow x = -\frac{13}{3}$$

ба $-\frac{13}{3} < -2$ тул шийд болно.

$-2 \leq x < 1$ үед $|2x+4| = 2x+4$, $|x-1| = -x+1$ тул

$$2x+4-x+1=10 \Leftrightarrow x=5$$

боловч $-2 \leq x < 1$ мужид орохгүй тул шийд болохгүй.


$1 \leq x$ үед $|2x+4| = 2x+4$, $|x-1| = x-1$ тул

$$2x+4+x-1=10 \Leftrightarrow 3x=7 \Rightarrow x=\frac{7}{3}$$

ба $1 \leq \frac{7}{3}$ тул шийд болно.

Иймд шийдүүдийн нийлбэр нь $-\frac{13}{3} + \frac{7}{3} = -2$ байна.

10.22.



$f'(x) = 3ax^2 + 6ax = 0 \Rightarrow x_1 = -2, x_2 = 0$. Тэгвэл $x = 0$ цэг дээр хамгийн бага утгатай. Иймд $f(0) = b = -10$. Түүнчлэн $x = -1, x = 2$ -ийн аль нэг дээр хамгийн их утгатай байна.
 $f(-1) = 2a - 10, f(2) = 20a - 10$ ба $a > 0$ тул

$$f(2) > f(-1)$$

буюу $x = 2$ үед хамгийн их утгатай. Иймд $20a - 10 = 10 \Rightarrow a = 1$ тул $|a+b| = |1-10| = 9$.

10.23.

$$\begin{aligned} f(x) &= \int f'(x) dx = \int \frac{dx}{x^2 - 5x + 6} \\ &= \int \frac{dx}{(x-2)(x-3)} = \int \frac{1}{x-3} - \frac{1}{x-2} dx \\ &= \int \frac{dx}{x-3} - \int \frac{dx}{x-2} = \ln|x-3| - \ln|x-2| + C \\ &= \ln \left| \frac{x-3}{x-2} \right| + C \end{aligned}$$

байна. Иймд

$$f(4) = \ln \left| \frac{4-3}{4-2} \right| + C = \ln \frac{1}{2} + C = -\ln 2 + C$$

байна. Нөгөө талаас $f(4) = -\ln 2$ тул $C = 0$ болов. Иймд $f(x) = \ln \left| \frac{x-3}{x-2} \right|$ байна.

10.24. Мужийг у тэнхлэгийг тойруулан эргүүлж байгаа учраас у-тэнхлэгт перпендикуляр зүсэлт (хөндлөн огтлол нь дугуй байхаар) хийж у-ээр интегралчлах нь зүйтэй. Хэрэв у өндөрт зүсэлт хийвэл x радиустай дугуй диск үүсэх бөгөөд $x = \sqrt[3]{y}$ байна. Иймд у цэгийг дайрсан хөндлөн огтлолын талбай нь

$$S(y) = \pi x^2 = \pi y^{\frac{2}{3}}$$

болно. Бие $y = 0$, $y = 8$ хавтгайн хооронд орших тул эзлэхүүн нь

$$V = \int_0^8 S(y) dy = \int_0^8 \pi y^{\frac{2}{3}} dy = \pi \left[\frac{3}{5} y^{\frac{5}{3}} \right]_0^8 = \frac{96\pi}{5}$$

гэж олдоно.

10.25. Эхний хоолойг 10 минут, хоёрдугаар хоолойг 20 минут ажиллуулбал бассейн дүүрнэ. Иймд эхний хоолойг 5 минут, хоёрдугаар хоолойг 10 минут ажиллуулахад бассейны хагас нь дүүрнэ. Эндээс хоёрдугаар хоолойг 5 минут ажиллуулахад бассейны $\frac{3}{5} - \frac{1}{2} = \frac{1}{10}$ хэсэг дүүрэх тул 50 минутад хоёрдугаар хоолой бассейныг дүүргэнэ.


Хоёрдугаар хоолойг 20 минут ажиллуулбал бассейны $\frac{20}{5} \cdot \frac{1}{10} = \frac{2}{5}$ хэсэг дүүрнэ. Эндээс 10 минутанд эхний хоолой бассейны $1 - \frac{2}{5} = \frac{3}{5}$ хэсгийг дүүргэнэ. Иймд $10 : \frac{3}{5} = \frac{50}{3}$ минутад нэгдүгээр хоолой бассейныг дүүргэнэ.

11. Хавтгайн геометр 2

11.1.

$$\alpha = 40^\circ + 80^\circ = 120^\circ$$

11.2. Сууриас татсан медианы уртыг m гэвэл хүндийн төвөөс суурийн орой хүртэлх зай $\frac{2}{3}m$ байна.



$$S_{\triangle BGC} = \frac{1}{2} \cdot \left(\frac{2}{3}m\right)^2 \cdot \sin 120^\circ = \frac{1}{3}S = \frac{\sqrt{3}}{3} \Rightarrow$$

$$\left(\frac{2}{3}m\right)^2 = \frac{\sqrt{3}}{3} : \frac{\sin 120^\circ}{2} = \frac{4}{3}$$

байна. Суурийн урт нь косинусын теоремоор

$$BC = \sqrt{2 \cdot \left(\frac{2}{3}m\right)^2 - 2 \cdot \left(\frac{2}{3}m\right)^2 \cos 120^\circ} =$$

$$= \sqrt{2 \cdot \frac{4}{3} - 2 \cdot \frac{4}{3} \cdot \left(-\frac{1}{2}\right)} = 2$$

11.3. Их тал нь 7 тул түүний эсрэг орших өнцгийн косинус нь:

$$\cos \alpha = \frac{5^2 + 6^2 - 7^2}{2 \cdot 5 \cdot 6} = \frac{25 + 36 - 49}{60} = \frac{1}{5}$$

байна.

11.4. Гурвалжны өнцгүүдийн нийлбэр 180° тул

$$\angle B = 180^\circ - \angle A - \angle C = 180^\circ - 75^\circ - 45^\circ = 60^\circ$$

Иймд синусын теоремоор

$$\frac{AC}{\sin 60^\circ} = \frac{BC}{\sin 75^\circ} \Rightarrow BC = \frac{6\sqrt{2}}{\sin 60^\circ} \cdot \sin 75^\circ$$

болно.

$$\sin 75^\circ = \sin(45^\circ + 30^\circ) = \frac{\sqrt{2}}{2} \cdot \frac{1}{2} + \frac{\sqrt{2}}{2} \cdot \frac{\sqrt{3}}{2} = \frac{\sqrt{2} + \sqrt{6}}{4}$$

$$\text{ба } \sin 60^\circ = \frac{\sqrt{3}}{2} \text{ тул}$$

$$BC = \frac{6\sqrt{2}}{\frac{\sqrt{3}}{2}} \cdot \frac{\sqrt{2} + \sqrt{6}}{4} = \frac{12 + 12\sqrt{3}}{2\sqrt{3}} = 2\sqrt{3} + 6$$

11.5.

$$\ell = \frac{2 \cdot 3\sqrt{2} \cdot 2\sqrt{2}}{3\sqrt{2} + 2\sqrt{2}} \cdot \cos 45^\circ = \frac{12\sqrt{2}}{5} \cdot \frac{\sqrt{2}}{2} = \frac{12}{5} = 2.4$$

11.6. $BC_1 = 2 \cos 45^\circ = 2 \cdot \frac{\sqrt{2}}{2} = \sqrt{2}$ байна. Нөгөө талаас $\triangle BC_1H$ тэгш өнцөгт гурвалжнаас $\cos \angle B_1BA = \cos \angle HBC_1 = \frac{BC_1}{BH}$ тул

$$BH = \frac{BC_1}{\cos 30^\circ} = \frac{\sqrt{2}}{\frac{\sqrt{3}}{2}} = \frac{2\sqrt{6}}{3} = 2\sqrt{6} : 3$$

байна.

11.7. Медианы уртыг олох томъёоноос хамгийн урт медиан нь богино талд буусан медиан байх тул

$$d = \frac{1}{2} \sqrt{2(7^2 + 8^2) - 5^2} = \frac{\sqrt{201}}{2}$$

байна.

11.8. Адил хажуут тул оройгоос буусан өндөр нь сууриа 5, 5 урттай хэсгүүдэд хуваана. Өндрийг Пифагорын теоремоор олбол


$$h = \sqrt{13^2 - 5^2} = 12$$

тул талбай нь

$$S = \frac{1}{2} \cdot 10 \cdot 12 = 60$$

байна.

11.9.



Гурвалжны медианууд гурвалжинг тэнцүү талбайтай 6 жижиг гурвалжинд хуваадаг. Мөн оройгоос 2 : 1 харьцаатай хуваагддаг тул нэг нь 3,8 талтай тэгш өнцөгт гурвалжин байна. Иймд жижиг гурвалжны талбай $\frac{3 \cdot 8}{2} = 12$, том гурвалжны талбай $6 \cdot 12 = 72$ байна.

11.10. Төсөөгийн коэффициент нь $k = \frac{16}{40} = \frac{2}{5}$ байна. Гурвалжнуудын талбайг S_1, S_2 гэвэл $S_1 + S_2 = 87$ см.кв ба

$$\frac{S_1}{S_2} = \left(\frac{2}{5}\right)^2 = \frac{4}{25}$$

тул $S_2 = \frac{25}{4} S_1$ байна. Үүнийг эхний тэгшитгэлд орлуулбал:

$$S_1 + \frac{25}{4} S_1 = 87 \Rightarrow S_1 = \frac{87 \cdot 4}{29} = 12$$


байна.

11.11. Биссектриссийн чанар ёсоор

$$\frac{AB}{BN} = \frac{AC}{NC} \Leftrightarrow \frac{8}{x+2} = \frac{5}{x} \Leftrightarrow 8x = 5x + 10 \Leftrightarrow x = \frac{10}{3}$$

байна.

11.12.




Багтаасан тойргийн төвийг O , өндрүүдийн суурийг A_1, B_1, C_1 , багтаасан тойргийн төвөөс талууд хүртэлх зайг d_1, d_2, d_3 гэе. $AB_1 = AB \cos \alpha$, $AC_1 = AC \cos \alpha$ ба A орой дахь өнцөг ерөнхий тул $\triangle ABC \sim \triangle AB_1C_1$ байна. Иймд $B_1C_1 = BC \cos \alpha$. Үүнтэй төстэйгээр $A_1B_1 = AB \cos \gamma$, $A_1C_1 = AC \cos \beta$. Мөн $\angle BOC = 2\alpha$ тул $d_1 = R \cos \alpha$ болно. Мөн адил шалтгаанаар $d_2 = R \cos \beta$, $d_3 = R \cos \gamma$.

$$\begin{aligned}
 S &= \frac{AB \cdot d_1 + AC \cdot d_2 + BC \cdot d_3}{2} \\
 &= \frac{AB \cdot R \cos \gamma + AC \cdot R \cos \beta + BC \cdot R \cos \alpha}{2} \\
 &= \frac{R(A_1B_1 + A_1C_1 + B_1C_1)}{2} \\
 &= \frac{2\sqrt{3} \cdot 9}{2} = 9\sqrt{3}
 \end{aligned}$$

11.13.

$$r \cdot R = \frac{S}{p} \cdot \frac{abc}{4S} = \frac{abc}{4p} = \frac{abc}{2(a+b+c)} = \frac{6 \cdot 25 \cdot 29}{2 \cdot (6+25+29)} = 36.25$$

11.14.



Багтсан тойргийн төвөөс гурвалжны аль нэг тал α өнцгөөр харагдах бол суурийн хоёр өнцгийн нийлбэр нь $180^\circ - \alpha$ байна. Эдгээр өнцгүүд нь том гурвалжны өнцгийн хагас өнцгүүд тул том гурвалжны суурийн өнцгүүдийн нийлбэр $2 \cdot (180^\circ - \alpha) = 360^\circ - 2\alpha$ байна. Орой дахь өнцөг нь энэ нийлбэрийн 180° хүртэлх гүйцээлт тул

$$180^\circ - (360^\circ - 2\alpha) = 2\alpha - 180^\circ$$

байна.

Гурвалжны орой дахь өнцгийн косинус нь

$$\cos(2\alpha - 180^\circ) = -\cos 2\alpha = 1 - 2\cos^2 \alpha = \frac{4}{5}$$

байна. Иймд косинусын теоремоор


$$a^2 = 12^2 + 15^2 - 2 \cdot 12 \cdot 15 \cdot \frac{4}{5} = 81$$

тул гурав дахь тал нь $a = 9$ байна.

11.15. Параллелограммын чанар ба бодлогын нөхцөлөөс

$$e^2 + 6^2 = 2 \cdot 50 \Rightarrow e^2 = 100 - 36 = 64 \Rightarrow e = 8$$


11.16. Их суурийг AD , бага суурийг BC , AD хэрчмийн дундажыг E гэвэл $\vec{BC} = \vec{AE}$ тул $ABCE$ параллелограмм болно.



Солбисон өнцгүүд тул $\angle EAC = \angle ACB$ ($AD \parallel BC$). Мөн AC биссектрис тул $\angle ACB = \angle BAC$ болох тул $\triangle ABC$ адил хажуут байна. Эндээс $ABCE$ ромбо болно.

$ED = \frac{AD}{2} = BC = AB = CD = CE$ тул $\triangle CED$ зөв гурвалжин байна. Иймд трапецийн хурц өнцөг буюу $\angle ADE = 60^\circ$ байна.

11.17.




$AB = 3$, $CD = 1$, $AB \parallel CD$ гэе. Диагоналиудын огтлолцолын цэг O нь AB диаметртэй тойрог дээр байна. O цэгээс CD хүртэлх зай h ба $\triangle AOB \sim \triangle COD$ (төсөөгийн коэффициент нь $\frac{AB}{CD} = 3$) тул O цэгээс AB хүртэлх зай $3h$, трапецийн өндөр нь $4h$, талбай нь

$$\frac{1+3}{2} \cdot 4h = 8h$$

байна. $3h$ нь AB диаметртэй тойргийн радиус буюу $3h = \frac{3}{2} \Rightarrow h = \frac{1}{2}$ үед трапецийн өндөр хамгийн их байна. Иймд

$$\max S = 8 \cdot \frac{1}{2} = 4$$

11.18. Зөв 12 өнцөгтийн талбай нь зураг дээрх OAB -гурвалжны талбайгаас 12 дахин их байна.



OAB гурвалжны талбай

$$S_{\triangle OAB} = \frac{1}{2} \cdot OA \cdot OB \cdot \sin 30^\circ = \frac{1}{2} \cdot 1 \cdot 1 \cdot \frac{1}{2} = \frac{1}{4}$$

тул зөв 12 өнцөгтийн талбай $12 \cdot \frac{1}{4} = 3$ байна.

11.19. $\widehat{AB} : \widehat{BC} : \widehat{CD} : \widehat{DA} = 2 : 3 : 4 : 9$ тул $\widehat{AB} = 2x$, $\widehat{BC} = 3x$, $\widehat{CD} = 4x$, $\widehat{DA} = 9x$ байна.

$$\widehat{AB} + \widehat{BC} + \widehat{CD} + \widehat{DA} = 18x = 360^\circ \Rightarrow x = 20^\circ$$

Иймд $\widehat{BC} = 3x = 60^\circ$, $\widehat{AD} = 9x = 180^\circ$ тул

$$\alpha = \frac{60^\circ + 180^\circ}{2} = 120^\circ$$


11.20. d диагоналын урт бол багтаасан тойргийн радиус нь $R = \frac{d}{2}$, багтсан тойргийн

радиус нь квадратын талын уртын хагас буюу $r = \frac{d}{2\sqrt{2}}$ байна. Иймд уртуудын харьцаа нь

$$\frac{\ell_1}{\ell_2} = \frac{2\pi R}{2\pi r} = \frac{R}{r} = \frac{\frac{d}{2}}{\frac{d}{2\sqrt{2}}} = \sqrt{2}$$

байна.


11.21. 1-р бодолт. 30 дм=3 м.



$AD = 2 \cdot 3 = 6$ м. Тойрог багтаасан дөрвөн өнцөгтийн чанараар

$$AB + CD = 6 + \frac{82}{3} = 33\frac{1}{3} \text{ м}$$

Энэ нь зөвхөн C хариултын хувьд биелэх тул зөв хариулт нь C юм. 2-р бодолт. 30 дм=3 м.



$AD = 2 \cdot 3 = 6$. Тойрог багтаасан дөрвөн өнцөгтийн чанараар

$$AB + CD = 6 + \frac{82}{3} = 33\frac{1}{3} \quad (*)$$

$\triangle BB_1C$ тэгш өнцөгт гурвалжны хувьд Пифагорын теорем бичвэл

$$B_1C^2 = BC^2 - BB_1^2$$

буюу


$$(CD - AB)^2 = \left(\frac{82}{3}\right)^2 - 6^2 = \frac{82^2 - 18^2}{9} = \frac{6400}{9}$$

тул

$$CD - AB = \frac{80}{3} \quad (**)$$

$(*)$, $(**)$ -г нэмбэл $2CD = \frac{100}{3} + \frac{80}{3} = 60 \Rightarrow CD = 30$, $AB = 33\frac{1}{3} - 30 = \frac{10}{3}$ болно.

11.22.



$\triangle OCD$ нь адил хажуут гурвалжин ба оройн өнцөг нь 60° тул суурийн өнцгүүд нь

$$\alpha = \frac{180^\circ - 60^\circ}{2} = 60^\circ$$

тул зөв гурвалжин байна. Иймд


$$OA = OC = OD = CD = BC = R$$

ба $BD = 2R$ байна. Шүргэгч ба огтлогчийн чанараар $BA^2 = BC \cdot BD$ тул

$$(\sqrt{6})^2 = R \cdot 2R \Rightarrow R = \sqrt{3}$$

Пифагорын теоремоор $OB^2 = OA^2 + BA^2$ тул $OB^2 = (\sqrt{3})^2 + (\sqrt{6})^2 = 9$ тул $OB = 3$ байна.

11.23.



$AB = d$, AB -ийн дундаж цэг нь M бол $\angle AOM = \angle BAN = \alpha$, M ба N орой дахь өнцгүүд нь 90° тул $\triangle AOM \sim \triangle BAN$ байна. Иймд

$$\frac{OA}{AM} = \frac{AB}{BN} \Leftrightarrow \frac{r}{\frac{d}{2}} = \frac{d}{a}$$

гэдгээс $d = \sqrt{2ar}$ байна.

11.24.

1. Косинусын теоремоор:

$$\cos \beta = \frac{1^2 + 2^2 - (\sqrt{2})^2}{2 \cdot 1 \cdot 2} = \frac{3}{4}$$

$\sin \beta > 0$ тул үндсэн адилтгалаар


$$\sin \beta = \sqrt{1 - \left(\frac{3}{4}\right)^2} = \frac{\sqrt{7}}{4}$$

$$2. S = \frac{1}{2}ca \sin \beta = \frac{1}{2} \cdot 1 \cdot 2 \cdot \frac{\sqrt{7}}{4} = \frac{\sqrt{7}}{4} \text{ байна.}$$

$$3. r = \frac{2S}{a+b+c} = \frac{\frac{\sqrt{7}}{2}}{2+\sqrt{2}+1} = \frac{\sqrt{7}}{2(3+\sqrt{2})} = \frac{\sqrt{7}(3-\sqrt{2})}{14}$$

$$4. R = \frac{b}{2 \sin \beta} = \frac{\sqrt{2}}{2 \cdot \frac{\sqrt{7}}{4}} = \frac{2\sqrt{2}}{\sqrt{7}} = \frac{2\sqrt{14}}{7} \text{ байна.}$$

11.25.



$$\triangle ACD \text{ гурвалжны хувьд синусын теорем бичвэл } 2R = \frac{\sqrt{2}}{\sin 45^\circ} \Rightarrow R = 1.$$

Нэг нумд тулсан өнцгүүд тул $\angle BDC = \angle BAC$ байна. $\sin \angle ABD = \frac{AD}{2R} = \frac{\sqrt{3}}{2}$ тул $\angle ABC = 60^\circ$ байна. Иймд

$$\angle BAC = 180^\circ - 60^\circ - 60^\circ = 60^\circ \Rightarrow \angle BAC = 60^\circ - 45^\circ = 15^\circ$$

$\triangle ABD$ нь зөв гурвалжин тул $AB = \sqrt{3} \Rightarrow AB^2 = 3$ байна.

12. Огторгуйн геометр 2


12.1. $\sqrt{3}a = 10$ тул $a = \frac{10}{\sqrt{3}} = \frac{10\sqrt{3}}{3}$ байна. Иймд $V = a^3 = \left(\frac{10\sqrt{3}}{3}\right)^3 = \frac{\sqrt{3}}{9} \cdot 1000$ байна.

12.2. Талуудын уртыг нь a, b, c гэвэл эзлэхүүн нь $V_1 = abc$ шинээр үүсэх параллелепипедийн талууд $3a, 3b, 3c$ тул эзлэхүүн нь

$$V_2 = 3a \cdot 3b \cdot 3c = 27abc = 27V_1$$

байна. Иймд эзлэхүүн нь 27 дахин ихсэнэ.

12.3.



Призмийн суурийн талын уртыг $2a$ гэвэл суурийн диагоналын уртын хагасын квадрат нь $a^2 + a^2 = 2a^2$ байна. Иймд $2a^2 + 2^2 = 3^2 \Rightarrow a^2 = \frac{5}{2}$ байна. Призмийн эзлэхүүн $4a^2 \cdot 4 = 16a^2 = 16 \cdot \frac{5}{2} = 40$, бөмбөрцгийн эзлэхүүн $\frac{4}{3} \cdot \pi \cdot 3^3 = 36\pi$ байна. Иймд бидний олох харьцаа

$$V = \frac{40}{36\pi} = \frac{10}{9\pi}$$


12.4. Суурийн тойргийн радиусыг r гэвэл урт нь $a = \sqrt{48\pi} = 2\pi r$ байна. Иймд $r = \frac{\sqrt{48\pi}}{2\pi}$ байна. Иймд суурийн талбай нь

$$S = \pi r^2 = \pi \cdot \left(\frac{\sqrt{48\pi}}{2\pi}\right)^2 = \pi \cdot \frac{48\pi}{4\pi^2} = 12$$

12.5.

$$V_0 = \frac{4\pi R^3}{3} = 168 \Rightarrow V_y = 2\pi R^3 = \frac{168 \cdot 3}{2} = 252.$$

12.6.



Пирамидын нэг талсын талбайг S_1 гэвэл түүний суурь дээрх проекцийн талбай нь $S_1 \cos \theta$ байна (хажуу талсын суурь дээрх проекцийн өндөр нь апофемыг $\cos \theta$ -аар үржүүлэхэд гарна). Хажуу гадаргуугийн талбай $4S_1$, тэдгээрийн суурь дээрх проекцүүдийн нийлбэр буюу суурийн талбай $4S_1 \cos \theta$ тул

$$\cos \theta = \frac{4S_1 \cos \theta}{4S_1} = 1 : \sqrt{3} = \frac{1}{\sqrt{3}}$$

байна. Иймд $\theta = \arccos \frac{1}{\sqrt{3}}$.

12.7. Багтсан конусын эзлэхүүн

$$V_1 = \frac{1}{3} \pi r^2 H = \frac{1}{3} \pi \frac{a^2}{4} \operatorname{tg}^2 \frac{180^\circ}{n} H,$$

багтаасан конусын эзлэхүүн

$$V_2 = \frac{1}{3} \pi R^2 H = \frac{1}{3} \pi \frac{a^2}{4} \operatorname{csc}^2 \frac{180^\circ}{n} H$$

тул

$$V_1 : V_2 = \operatorname{ctg}^2 \frac{180^\circ}{n} : \operatorname{csc}^2 \frac{180^\circ}{n} = 1 : 4$$

байна. $\alpha = \frac{180^\circ}{n}$ гэвэл

$$\frac{\cos^2 \alpha}{\sin^2 \alpha} : \frac{1}{\sin^2 \alpha} = \frac{1}{4} \Rightarrow 4 \cos^2 \alpha = 1$$

болно. Эндээс $\cos \alpha > 0$ тул $\cos \alpha = \frac{1}{2}$ буюу $\alpha = 60^\circ$ болов. Иймд

$$\frac{180^\circ}{n} = 60^\circ \Rightarrow n = 3$$

болов.

12.8. ABC гурвалжны төв нь H , MN хэрчмийн дундаж цэг F гэвэл бидний олох өнцөг нь $\angle DFH$ байна.

$$DM = a \sin 60^\circ = \frac{\sqrt{3}a}{2}$$

$$MF = \frac{1}{2}MN = \frac{1}{4}a$$

Тул DFM тэгш өнцөгт гурвалжнаас

$$DF = \sqrt{DM^2 - MF^2} = \sqrt{\frac{3a^2}{4} - \frac{a^2}{16}} = \frac{\sqrt{11}a}{4}$$

$\angle HNF = \angle HCA = 30^\circ$ тул

$$HF = NF \cdot \operatorname{tg} 30^\circ = \frac{1}{4}a \cdot \frac{1}{\sqrt{3}} = \frac{\sqrt{3}a}{12}$$

DHF тэгш өнцөгт гурвалжнаас

$$\cos \angle DFH = \frac{HF}{DF} = \frac{\frac{\sqrt{3}a}{12}}{\frac{\sqrt{11}a}{4}} = \frac{1}{\sqrt{33}}$$

тул

$$\sin \angle DFH = \sqrt{1 - \cos^2 \angle DFH} = \sqrt{\frac{32}{33}} = \frac{4\sqrt{66}}{33}$$

12.9. Конус өндөр нь Пифагорын теоремоор $h^2 = \ell^2 - r^2$ байна.

$$8^2 = 17^2 - r^2 \Rightarrow r = 15$$

Иймд $S = \pi \cdot 17 \cdot 15 = 255\pi$ болов.

12.10. $AC^2 = AB^2 + BC^2$ тул ABC нь тэгш өнцөгт гурвалжин байна. Иймд $R_{ABC} = \frac{10}{2} = 5$ байна. $R_{ABC}^2 + 12^2 = R^2$ байна.

$R^2 = 5^2 + 12^2 = 169$ тул бөмбөрцгийн гадаргуугийн талбай нь $4 \cdot 169\pi = 676\pi$ байна.

12.11. Бөмбөрцгийн төв нь координатын эх ба радиус нь $OB = \sqrt{64} = 8$ байна. А цэгээс координатын эх хүртэлх зай:

$$OA = \sqrt{(-1)^2 + 7^2 + (5\sqrt{2})^2} = \sqrt{100} = 10$$

$\angle ABO = 90^\circ$ байх тул Пифагорын теоремоор:

$$OA^2 = AB^2 + OB^2 \Rightarrow AB^2 = 100 - 64 = 36 \Rightarrow AB = 6$$

12.12. AB хэрчмийн дундаж C_1 цэгийн координат:

$$C_1 \left(\frac{-2+6}{2}, \frac{4+2}{2}, \frac{6+4}{2} \right) = C_1(2, 3, 5)$$

CC_1 медианы урт:

$$CC_1 = \sqrt{(2-1)^2 + (3-(-1))^2 + (5-(-3))^2} = \sqrt{81} = 9$$

12.13. $(x; y) = (3; -3)$ үед

$$3^2 + 2 \cdot 3 + (-3)^2 + 6 \cdot (-3) - 6 = 0$$

тул $(3; -3)$ цэг муруй дээр оршино.

12.14. $2x + 3y = 5$, $-3x + 2y = 5$ шулуунуудын хувьд $2 \cdot (-3) + 3 \cdot 2 = 0$ тул перпендикуляр байна.

12.15.

$$\begin{cases} 2x - y + z - 5 = 0 \\ 3x + 4y + z - 11 = 0 \\ x - y + z - 4 = 0 \end{cases}$$

1-р тэгшитгэлээс 3-р тэгшитгэлийг хасвал

$$(2x - y + z - 5) - (x - y + z - 4) = 0 \Rightarrow x - 1 = 0$$

буюу $x = 1$ байна. Үүнийг 1 ба 2-р тэгшитгэлд орлуулбал $2 - y + z - 5 = 0$, $3 + 4y + z - 11 = 0$ болно. Эдгээрийн ялгавар нь

$$(2 - y + z - 5) - (3 + 4y + z - 11) = -5y + 5 = 0 \Rightarrow y = 1$$

болно. Иймд $2 - 1 + z - 5 = 0$ буюу $z = 4$ байна. Иймд огтлолцолын цэгийн координат нь $(x, y, z) = (1, 1, 4)$ байна.

12.16.

$$\begin{aligned} \vec{a} \cdot \vec{b} &= 1 \cdot 0 + 1 \cdot \lambda + 0 \cdot 1 = \lambda \\ |\vec{a}| &= \sqrt{1^2 + 1^2 + 0^2} = \sqrt{2} \\ |\vec{b}| &= \sqrt{0^2 + \lambda^2 + 1^2} = \sqrt{\lambda^2 + 1} \end{aligned}$$

тул

$$\cos 60^\circ = \frac{1}{2} = \frac{\lambda}{\sqrt{2} \cdot \sqrt{\lambda^2 + 1}}$$

болно. Тэгшитгэлийн хоёр талыг квадрат зэрэгт дэвшүүлэн бодвол

$$\frac{1}{4} = \frac{\lambda^2}{2(\lambda^2 + 1)} \Leftrightarrow \lambda^2 = 1$$

Эндээс $\lambda > 0$ болохыг тооцвол $\lambda = 1$ болно.

12.17.

$$\begin{aligned} \vec{a} &= (2\vec{a} + \vec{b}) - (\vec{a} + \vec{b}) = (3; 4; 1) - (1; 3; 2) = (2; 1; -1) \\ \vec{b} &= (\vec{a} + \vec{b}) - \vec{a} = (1; 3; 2) - (2; 1; -1) = (-1; 2; 3) \end{aligned}$$

тул

$$\begin{aligned} \vec{a} \cdot \vec{b} &= (2; 1; -1) \cdot (-1; 2; 3) = \\ &= 2 \cdot (-1) + 1 \cdot 2 + (-1) \cdot 3 = -3 \end{aligned}$$

12.18. Векторууд коллинеар бол $\frac{5}{x} = \frac{y}{2} = \frac{-6}{2}$ байна. Эндээс $x = 10$ байна.

12.19. $(1; 3) = \lambda(x; y) \Rightarrow \lambda = \frac{1}{x} = \frac{3}{y} \Rightarrow 3x - y = 0$ байна.

12.20. $A = \frac{4}{3}\pi \cdot 3^3 = 36\pi$, $B = 4\pi \cdot 3^2 = 36\pi$. Суурийн радиус нь R байх h өндөртэй конусын эзлэхүүн $V = \frac{1}{3}\pi R^2 h$ тул $C = \frac{1}{3}\pi \cdot 3^2 \cdot 6 = 18\pi$. Иймд $C < A = B$ байна.

12.21.

1. SA ирмэгийн суурьтай үүсгэх өнцөг нь $\angle SAC = 60^\circ$, SC ирмэгийн суурьтай үүсгэх өнцөг нь $\angle SCA = 60^\circ$ тул $\triangle ASC$ нь 4 талтай зөв гурвалжин байна. $\triangle ASC$ -ийн SH өндөр нь пирамидын өндөр болох тул $h = SH = AS \cdot \sin 60^\circ = 4 \cdot \frac{\sqrt{3}}{2} = 2\sqrt{3}$.

2. Суурийн гипотенузын урт $AC = 4$. Катетууд нь $4 \cdot \sin 30^\circ = 2$, $4 \cdot \cos 30^\circ = 2\sqrt{3}$ тул талбай нь

$$S = \frac{1}{2} \cdot 2 \cdot 2\sqrt{3} = 2\sqrt{3}.$$

3. $V = \frac{1}{3}Sh$ тул

$$S = \frac{1}{3} \cdot 2\sqrt{3} \cdot 2\sqrt{3} = 4.$$

4. $\triangle ASC$ -г багтаасан тойргийн төв O нь багтаасан бөмбөрцгийн төв ($OB = OA = OC = OS$) болох тул багтаасан бөмбөрцгийн радиус нь $\triangle ASC$ -г багтаасан тойргийн радиус буюу

$$\frac{2}{3}h = \frac{2}{3} \cdot 2\sqrt{3} = \frac{4}{\sqrt{3}}$$

байна.

12.22. ADC гурвалжин ба SP шулууны хувьд Менелайн теорем бичвэл

$$\frac{AP}{PD} \cdot \frac{DN}{NC} \cdot \frac{CS}{SA} = 1$$

байна. Иймд $\frac{2}{3} \cdot \frac{1}{1} \cdot \frac{CS}{SA} = 1$ буюу $\frac{CS}{SA} = \frac{3}{2}$. Эндээс $2SC = 3(SC - CA)$ буюу $SC = 3CA$ болж байна. Иймд $\overrightarrow{SC} = 3\overrightarrow{AC}$.

ABC гурвалжин ба SM шулууны хувьд Менелайн теорем бичвэл

$$\frac{AM}{MB} \cdot \frac{BQ}{QC} \cdot \frac{CS}{SA} = 1$$

болно. Иймд $\frac{1}{1} \cdot \frac{BQ}{QC} \cdot \frac{3}{2} = 1$ буюу $CQ : QB = 3 : 2$ байна.

12.23. $D(x; y; z)$ гэвэл $\overrightarrow{CD} = (x+2; y-4; z-1)$ ба


$$\overrightarrow{AB} = (1-2; 0-(-3); 8-5) = (-1; 3; 3)$$

тул

$$(x+2; y-4; z-1) = -3\overrightarrow{AB} = (3; -9; -9)$$

буюу $x+2=3$, $y-4=-9$, $z-1=-9$ болно. Иймд $x=1$, $y=-5$, $z=-8$ тул нийлбэр нь -12 байна.

12.24.



K цэг PQR гурвалжны хүндийн төв тул

$$\begin{aligned}\overrightarrow{AK} &= \frac{\overrightarrow{AP} + \overrightarrow{AQ} + \overrightarrow{AR}}{3} = \frac{1}{3} \left(\frac{2}{3} \overrightarrow{AB} + \frac{2}{3} \overrightarrow{AD} + \overrightarrow{AE} + \frac{\overrightarrow{AB} + \overrightarrow{AD}}{3} \right) = \\ &= \frac{1}{3} (\overrightarrow{AB} + \overrightarrow{AD} + \overrightarrow{AE}) = \frac{1}{3} \overrightarrow{AG} \Rightarrow \overrightarrow{AG} = 3\overrightarrow{AK}.\end{aligned}$$

Тул K цэг AG -г 1 : 2 харьцаагаар хуваана.

12.25.

1. AB хэрчмийн дундаж цэгийн координат нь

$$M\left(\frac{-6+2}{2}, \frac{1+5}{2}\right) = M(-2, 3)$$

байх ба CM шулууны тэгшитгэл

$$\frac{x-3}{-2-3} = \frac{y-(-2)}{3-(-2)} \Leftrightarrow -x+3 = y+2$$

тул

$$y = -x + 1$$

2. $\overrightarrow{AB} = B - A = (2; 5) - (-6; 1) = (8; 4)$, $\overrightarrow{AC} = (3; -2) - (-6; 1) = (9; -3)$ векторуудын хоорондох өнцгийн косинус нь

$$\cos \alpha = \frac{8 \cdot 9 + 4 \cdot (-3)}{\sqrt{8^2 + 4^2} \cdot \sqrt{9^2 + (-3)^2}} = \frac{60}{4\sqrt{5} \cdot 3\sqrt{10}} = \frac{\sqrt{2}}{2}$$

тул $\alpha = 45^\circ$ болно.

3. AB хэрчмийн дундаж цэг нь $\frac{A+B}{2} = \frac{(-6, 1) + (2, 5)}{2} = (-2, 3)$,

$\overrightarrow{AB} = (2 - (-6), 5 - 1) = (8, 4)$ тул дундаж перпендикуляр шулууны тэгшитгэл нь

$$8(x - (-2)) + 4(y - 3) = 0 \Leftrightarrow y = -2x - 1$$

$$AC \text{ хэрчмийн дундаж цэг нь } \frac{A+C}{2} = \frac{(-6, 1) + (3, -2)}{2} = (-1.5, -0.5),$$


$\overrightarrow{AC} = (3 - (-6), -2 - 1) = (9, -3)$ тул дундаж перпендикуляр улууны тэгшитгэл нь

$$9(x - (-1.5)) - 3(y - (-0.5)) = 0 \Leftrightarrow y = 3x + 4$$

болно. Иймд багтаасан тойргийн төв нь

$$\begin{cases} y = -2x - 1 \\ y = 3x + 4 \end{cases} \Rightarrow -2x - 1 = 3x + 4 \Rightarrow x = -1, y = 1$$

координаттай байна. (Зургаа зөв зураад зургаасаа багтаасан тойргийн төвийг олбол илүү хурдан байх боломжтой.)



Багтаасан тойргийн радиус нь $R = OA = |(-1) - (-6)| = 5$ болно. Иймд тэгшитгэл нь

$$(x + 1)^2 + (y - 1)^2 = 5^2$$

байна.

13. Геометр сэдвийн давтлага 2

13.1. Олох диагоналын уртыг d гэе. Параллелограммын чанар ёсоор

$$d^2 + 7^2 = 2 \cdot (3^2 + 5^2)$$

тул $d = \sqrt{68 - 49} = \sqrt{19}$ байна.

13.2. Катетуудыг a, b , гипотенузыг c гэвэл $a + b + c = 6$, $\frac{a}{b} = 2.4$, $a^2 + b^2 = c^2$ болно. Мөн

$$R + r = \frac{c}{2} + \frac{a + b - c}{2} = \frac{a + b}{2}$$

байна. $a = 2.4b$ тул $(2.4b)^2 + b^2 = (2.6b)^2 = c^2$ ба $b, c > 0$ тул $c = 2.6b$ байна. Иймд $2.4b + b + 2.6b = 6$ буюу $b = 1$, $a = 2.4$ тул

$$R + r = \frac{2.4 + 1}{2} = 1.7$$

13.3.

$$\frac{x}{1} = \frac{y}{-4} \Rightarrow 4x + y = 0$$

13.4.

$$c^2 = 2(11^2 + 23^2) - 4 \cdot 10^2 = 900 \Rightarrow c = 30$$

13.5. Цилиндрийн байгуулагч болон төвийг суурийн тойргийн цэгтэй холбоход үүсэх хэрчим хоёрын хоорондох өнцгийг θ гэвэл суурийн радиус нь $r = R \sin \theta$, өндөр нь $h = 2R \cos \theta$ байна. Суурийн периметр нь $2\pi r = 2\pi R \sin \theta$ тул хажуу гадаргуугийн талбай нь


$$S = 4\pi R^2 \sin \theta \cos \theta = 2\pi R^2 \sin 2\theta$$

байна. Эндээс $\theta = 45^\circ$ ($\sin 2\theta = 1$) үед хажуу гадаргуугийн талбай хамгийн их байх нь ээ. Энэ үед эзлэхүүн нь

$$V = S \cdot h = \pi (R \sin 45^\circ)^2 \cdot 2R \cos 45^\circ = \frac{\pi R^3}{\sqrt{2}}$$

байна.

13.6.



AA_1 хэрчмийн дундаж цэг M , BB_1 хэрчмийн дундаж цэг N бол MN нь AB -тэй параллель буюу BB_1C_1C хавтгайд перпендикуляр байна. Иймд $\angle MNC = 90^\circ$. Кубын талын уртыг $2x$ гэвэл

$$NC^2 = x^2 + (2x)^2$$

тул

$$MC_1^2 = MN^2 + NC^2 = (2x)^2 + 5x^2 = 9x^2 = 36$$

болно. Иймд талын урт нь $x = 2 \Rightarrow AB = 2 \cdot 2 = 4$ ба эзлэхүүн нь $V = 4^3 = 64$ байна.

13.7.

$$BH = \frac{BH_1}{\sin \gamma} = \frac{AB \cos \beta}{\sin \gamma},$$

$$HH_2 = \frac{AH_2}{\tan \gamma} = \frac{AB \cos \alpha \cos \gamma}{\sin \gamma}$$

тул

$$\begin{aligned}
 BH : HH_2 &= \frac{AB \cos \beta}{\sin \gamma} : \frac{AB \cos \alpha \cos \gamma}{\sin \gamma} \\
 &= \frac{\cos \beta}{\cos \alpha \cos \gamma} = \frac{\cos 40^\circ}{\cos 60^\circ \cos 80^\circ} \\
 &= \frac{2 \cos 40^\circ}{\cos 80^\circ} \quad \leftarrow \cos 60^\circ = \frac{1}{2}
 \end{aligned}$$

13.8.

$$3^2 - 2 \cdot 3 + (-3)^2 + 6 \cdot (-3) + 6 = 0$$

тул $(3; -3)$ цэг $x^2 - 2x + y^2 + 6y + 6 = 0$ тэгшитгэлтэй муруй дээр оршино. Бусад цэгүүдийн хувьд тэгшитгэлийн шийд биш болохыг харуулж болно. Жишээ нь $(0, -1)$ цэгийн хувьд:

$$0^2 - 2 \cdot 0 + (-1)^2 + 6 \cdot (-1) + 6 = 1 \neq 0$$

13.9.

$$\begin{aligned}
 (\vec{b} + \vec{a}) - (\vec{b} - \vec{a}) &= 2\vec{a} \Rightarrow \\
 2\vec{a} &= (1; 4; -3) - (3; 2; 5) = (-2; 2; -8) \Rightarrow \\
 \vec{a} &= (-1; 1; -4)
 \end{aligned}$$

ба

$$\begin{aligned}
 (\vec{b} + \vec{a}) + (\vec{b} - \vec{a}) &= 2\vec{b} \Rightarrow \\
 2\vec{b} &= (1; 4; -3) + (3; 2; 5) = (4; 6; 2) \Rightarrow \\
 \vec{b} &= (2; 3; 1)
 \end{aligned}$$

байна. Иймд

$$\vec{a} \cdot \vec{b} = (-1) \cdot 2 + 1 \cdot 3 + (-4) \cdot 1 = -3$$


$$13.10. S_{\triangle ADB} = \frac{4 \cdot \frac{\ell_a}{2}}{2} = \ell_a, S_{\triangle ADC} = \frac{6 \cdot \frac{\ell_a}{2}}{2} = 1.5\ell_a \text{ ба}$$

$$S_{\triangle ADB} + S_{\triangle ADC} = S$$

тул

$$\ell_a + 1.5\ell_a = \frac{1}{2} \cdot 4 \cdot 6 \cdot \sin 60^\circ$$

болно. Иймд $\ell_a = \frac{12\sqrt{3}}{5}$ байна.



Жич: Өнцгийн биссектрис нь тухайн өнцгийг үүсгэж буй цацрагуудаас ижил зайд алслагдсан цэгүүдийн олонлог байдаг.

13.11. a талтай зөв гурвалжны медианы урт нь $a \sin 60^\circ = \frac{\sqrt{3}}{2}a$ байна. Харин $\frac{\sqrt{3}}{2}a$

талтай зөв гурвалжны медианы урт нь $\frac{\sqrt{3}}{2} \cdot \frac{\sqrt{3}}{2}a = \frac{3}{4}a$ байна. Иймд зөвхөн C хариулт л зөв байх боломжтой.

13.12. Кубийн төвийг оройнуудтай холбовол талс бүр дээр суурьтай 6 ижил пирамид үүснэ. Эдгээрийн нэгдэл нь куб болох тул нэг бүрийнх нь эзлэхүүн $\frac{1}{6}V$ байна.

13.13. Байгуулагчийг ℓ гэвэл өндөр нь $h = \ell \cos 60^\circ = \frac{\ell}{2}$ байна. $\ell + \frac{\ell}{2} = 15 \Rightarrow \ell = 10$. Суурийн радиус нь

$$R = \sqrt{\ell^2 - h^2} = \sqrt{10^2 - 5^2} = \sqrt{75}$$

Суурийн талбай нь $S = \pi R^2 = 75\pi$, эзлэхүүн нь


$$V = \frac{1}{3}Sh = \frac{1}{3} \cdot 75\pi \cdot 5 = 125\pi$$

13.14. $(5k)^2 = (4k)^2 + (3k)^2$ тул гурвалжин маань тэгш өнцөгт гурвалжин байна. Иймд өндрүүд нь 15, 20 урттай катетуут болох тул талбай нь

$$S = \frac{15 \cdot 20}{2} = 150$$

Ерөнхий тохиолдолд $a = \frac{2S}{h_a}$, $b = \frac{2S}{h_b}$, $c = \frac{2S}{h_c}$ -ээс өнцгийн косинусыг олох, эсвэл Героны томьёонд орлуулж бодно.

13.15.



BC талын дундажаас AB -д татсан перпендикулярын урт 1 ба энэ нь $\triangle BCC_1$ -ийн дундаж шугам тул CC_1 өндрийн урт 2 байна. Түүнчлэн $\angle AC_1C = 90^\circ$ ба $\angle CAC_1 = 30^\circ$ тул

$$AC = \frac{CC_1}{\sin 30^\circ} = \frac{2}{\frac{1}{2}} = 4$$

байна.

13.16. Жижиг секторын талбай нь $\frac{1}{6}\pi \cdot 7^2 = \frac{49}{6}\pi$. Том секторын радиус нь $7 + 2 = 9$ тул талбай нь $\frac{1}{6}\pi \cdot 9^2 = \frac{81}{6}\pi$ байна. Иймд хар хэсгийн талбай нь $\frac{81 - 49}{6}\pi = \frac{16}{3}\pi$.

13.17. $BC = 4 + 3 = 7$ тул $AB + AC = 28 - 7 = 21$ байна. Иймд $AB = 21 - AC$ ба биссектрисийн чанар ёсоор

$$\frac{AB}{BD} = \frac{AC}{DC} \Rightarrow \frac{21 - AC}{4} = \frac{AC}{3} \Rightarrow AC = 9$$

13.18. $A(1; -3)$, $B(4; 1)$, $C(7; y)$, $D(x; 5)$ гэе.

$$\frac{A+C}{2} = \frac{B+D}{2} \Leftrightarrow \begin{cases} \frac{1+7}{2} = \frac{4+x}{2} \\ \frac{-3+y}{2} = \frac{1+5}{2} \end{cases} \Rightarrow \begin{cases} x=4 \\ y=9 \end{cases}$$

Эндээс $x + y = 13$.

13.19.

$$\begin{cases} \pi r^2 h = 63\pi \\ 2rh = 18 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} r^2 h = 63 \\ rh = 9 \end{cases}$$

Эндээс

$$r = \frac{\pi r^2 h}{rh} = \frac{63}{9} = 7$$

байна.

13.20. Суурь нь зөв гурвалжин ба түүнийг багтаасан тойрог нь бөмбөлөгийн их тойрог тул пирамидын суурийн талбай

$$S = 2R^2$$

ба өндөр $h = R$ байна. Эндээс

$$V = \frac{1}{3}Sh = \frac{1}{3} \cdot 2R^2 \cdot R = 18 \Rightarrow R = 3$$

13.21.

$$\begin{aligned}
 x^2 + y^2 - 4x + 6y &= 3 \\
 x^2 - 2 \cdot 2 \cdot x + 2^2 + y^2 + 2 \cdot 3 \cdot y + 3^2 &= 3 + 2^2 + 3^2 \\
 (x - 2)^2 + (y - 3)^2 &= 16
 \end{aligned}$$

байна. Иймд


$$x^2 + y^2 - 4x + 6y = 3 \Leftrightarrow (x - 2)^2 + (y + 3)^2 = 4^2$$

болох тул $A(2; -3)$, $r = 4$ байна.

13.22. Суурийн периметрийн хагас нь $p = \frac{26 + 28 + 30}{2} = 42$ тул Героны томьёо ёсоор талбай нь

$$S_{\triangle ABC} = \sqrt{42(42 - 26)(42 - 28)(42 - 30)} = \sqrt{42 \cdot 16 \cdot 14 \cdot 12} = 336$$

байна.



$\triangle SAB$ гурвалжны SE өндрийн проекц нь $\triangle DAB$ гурвалжны ED өндөр тул

$$\frac{S_{\triangle DAB}}{S_{\triangle SAB}} = \frac{\frac{1}{2} AB \cdot DE}{\frac{1}{2} AB \cdot SE} = \frac{DE}{SE} = \cos 60^\circ$$

буюу $S_{\triangle SAB} = \frac{S_{\triangle DAB}}{\cos 60^\circ}$ байна. Үүнтэй адилаар $S_{\triangle SAC} = \frac{S_{\triangle DAC}}{\cos 60^\circ}$, $S_{\triangle SBC} = \frac{S_{\triangle DBC}}{\cos 60^\circ}$ тул

$$S = \frac{S_{\triangle DAB} + S_{\triangle DAC} + S_{\triangle DBC}}{\cos 60^\circ} = \frac{S_{\triangle ABC}}{\cos 60^\circ} = 2 \cdot 336$$

ба бүтэн гадаргуун талбай нь

$$S = 3 \cdot 336 = 1008 \text{ кв.н}$$

13.23.

$$\vec{a} = (2\vec{a} + \vec{b}) - (\vec{a} + \vec{b}) = (3 - 1, 4 - 3, 1 - 2) = (2, 1, -1)$$

$$\vec{b} = (\vec{a} + \vec{b}) - \vec{a} = (1 - 2, 3 - 1, 2 - (-1)) = (-1, 2, 3)$$

$$\vec{a} \cdot \vec{b} = 2 \cdot (-1) + 1 \cdot 2 + (-1) \cdot 3 = -3$$

$$|\vec{a}| = \sqrt{2^2 + 1^2 + (-1)^2} = \sqrt{6}, |\vec{b}| = \sqrt{(-1)^2 + 2^2 + 3^2} = \sqrt{14} \text{ тул}$$

$$\cos \varphi = \frac{\vec{a} \cdot \vec{b}}{|\vec{a}| \cdot |\vec{b}|} = \frac{-3}{\sqrt{6} \cdot \sqrt{14}} = \frac{-3 \cdot \sqrt{6} \cdot \sqrt{14}}{6 \cdot 14} = -\frac{\sqrt{21}}{14}$$

13.24.

1. Тойрогт багтсан тул $\angle BCD = 180^\circ - \angle BAD$. Иймд $\cos \angle BCD = -\frac{1}{8}$ ба

$$\sin \angle BCD = \sqrt{1 - (-1/8)^2} = \sqrt{63/64} = \frac{3\sqrt{7}}{8}.$$

Синусийн теоремоор $\frac{BD}{\sin \angle BCD} = 2R$ буюу

$$BD = 2 \cdot \frac{8\sqrt{7}}{7} \cdot \frac{2 \cdot 3\sqrt{7}}{8} = 6.$$

Косинусын теоремоор

$$BD^2 = BC^2 + CD^2 - 2 \cdot BC \cdot CD \cos \angle BCD$$

байна. Иймд

$$6^2 = 4^2 + CD^2 - 2 \cdot 4 \cdot CD \cdot \left(-\frac{1}{8}\right)$$

буюу $CD^2 + CD - 20 = 0$ тэгшитгэлээс $CD = 4$ болно ($CD = -5$ шийд нь хэрчмийн урт болж чадахгүй).

2. $x^2 + y^2 + 2xy = 81$ ба $x^2 + y^2 - 2xy \cdot \frac{1}{8} = 36$. Тэгшитгэлүүдийг хасвал $\frac{9}{4}xy = 45$ буюу $xy = 20$. Талбай нь

$$\begin{aligned} S &= S_{\triangle ABD} + S_{\triangle BCD} \\ &= \frac{1}{2}xy \sin \angle BAD + \frac{1}{2} \cdot 4 \cdot 4 \cdot \sin \angle BCD \\ &= (10 + 8) \frac{3\sqrt{7}}{8} = \frac{27\sqrt{7}}{4} \end{aligned}$$

13.25. ABD ба BDC гурвалжнуудад косинусын теорем бичвэл

$$BD^2 = 5^2 + 3^2 - 2 \cdot 5 \cdot 3 \cdot \cos \angle A = 7^2 + 7^2 - 2 \cdot 7 \cdot 7 \cdot \cos \angle C.$$

$$\angle A + \angle C = 180^\circ, \cos(180^\circ - \alpha) = -\cos \alpha \text{ тул}$$

$$30 \cos \angle C + 98 \cos \angle C = 98 - 34 \Rightarrow \cos \angle C = \frac{1}{2} \Rightarrow \angle C = 60^\circ, BD = 7$$


болно. Тойрогт багтсан дөрвөн өнцөгтийн чанараар (Птолемейн теорем)

$$AC \cdot BD = AB \cdot CD + AD \cdot BC$$

буюу

$$AC \cdot 7 = 3 \cdot 7 + 5 \cdot 7.$$

Иймд $AC = 8$ болно.



$ABCD$ дөрвөн өнцөгтийн талбай

$$S = S_{ABD} + S_{BCD} = \frac{1}{2} \cdot 7 \cdot 7 \sin 60^\circ + \frac{1}{2} \cdot 3 \cdot 5 \cdot \sin 120^\circ = 16\sqrt{3}$$

байна. O тойргийн радиус $\frac{BD}{2 \sin 60^\circ} = \frac{7\sqrt{3}}{3}$ байна. ABD гурвалжинд багтсан тойргийн радиус

$$\frac{2S_{ABD}}{AB + BD + DA} = \frac{AB \cdot AD \cdot \sin 120^\circ}{3 + 7 + 5} = \frac{\frac{15\sqrt{3}}{2}}{15} = \frac{\sqrt{3}}{2}$$

байна. $ABCD$ дөрвөн өнцөгтийн диагоналиудын огтолцолын цэг E бол

$$S = \frac{1}{2} AC \cdot BD \cdot \sin \angle AEB \text{ буюу } 16\sqrt{3} = \frac{1}{2} \cdot 8 \cdot 7 \cdot \sin \angle AEB. \text{ Эндээс } \sin \angle AEB = \frac{4\sqrt{3}}{7} \text{ байна.}$$

14. Комбинаторик 2

14.1.

$$A_{n+2}^4 = \frac{(n+2)!}{(n+2-4)!} = (n+2)(n+1)n(n-1)$$

$$P_4 = 4! = 4 \cdot 3 \cdot 2 \cdot 1 = 24$$

$$C_n^{n-2} = \frac{n!}{\{n - (n-2)\}! \cdot (n-2)!} = \frac{n(n-1)}{2!}$$

тул

$$(n+2)(n+1)n(n-1) = 6 \cdot 24 \cdot \frac{n(n-1)}{2}$$

болно. C_n^{n-2} тул $n-2 \geq 0$ буюу $n \geq 2$ тул

$$(n+2)(n+1) = 72 \Rightarrow n^2 + 3n - 70 = 0 \Rightarrow n_1 = 7, n_2 = -10$$

байна. Иймд $n = 7$.

14.2.

$$8!C_{10}^2 = 8! \cdot \frac{10!}{(10-8)! \cdot 8!} = \frac{10!}{(10-8)!} = A_{10}^8$$

14.3. $n = 2010$ тул коэффициент нь

$$C_{2015}^{2010} = \frac{2015!}{(2015-2010)! \cdot 2010!} = \frac{2015!}{5! \cdot 2010!}$$

14.4. $\left(\sqrt{x} - \frac{\sqrt{2}}{\sqrt[4]{x}}\right)^8$ биномын задаргаа 9 гишүүнтэй тул дундаж гишүүн нь 5-р гишүүн байна. Иймд

$$T_{4+1} = C_8^4 (\sqrt{x})^{8-4} \left(\frac{\sqrt{2}}{\sqrt[4]{x}}\right)^4 = \frac{8!}{4! \cdot 4!} \cdot x^2 \cdot \frac{4}{x} = 280x$$

байна.

14.5.

$$\begin{aligned} 2^{100} &= (3 + (-1))^{100} = C_{100}^{100} \cdot 3^{100} \cdot (-1)^0 + C_{100}^{99} \cdot 3^{99} \cdot (-1)^1 + \dots + C_{100}^0 \cdot 3^0 \cdot (-1)^{100} \\ &= 3^{100} \cdot C_{100}^{100} - 3^{99} \cdot C_{100}^{99} + 3^{98} \cdot C_{100}^{98} - \dots - 3^1 \cdot C_{100}^1 + 1 \end{aligned}$$

14.6. А сагсан бөмбөг тоглодог хүүхдүүд, В даам тоглодог хүүхдүүд гэвэл сагсан бөмбөг ба даам тоглодог хүүхдүүд нь $A \cap B$ байна.

$$|A \cup B| = 20 - 2 = 18$$

Нөгөө талаас $|A \cap B| = |A| + |B| - |A \cup B|$ тул

$$|A \cap B| = 10 + 12 - 18 = 4$$

байна.

14.7. Бидний олох тоо $a + b + c + d = 20$ тэгшитгэлийн сөрөг биш бүхэл тоон шийдийн тоотой тэнцүү тул

$$C_{(4)}^{20} = \overline{C_4^{20}} = C_{20+4-1}^{20} = C_{23}^{20} = \frac{23!}{3! \cdot 20!} = 1771$$

14.8. $1260 = 2^2 \cdot 3^2 \cdot 5^1 \cdot 7^1$ байна. Иймд хуваагчдын тоо нь $(2+1)(2+1)(1+1)(1+1) = 36$.

14.9. Бөхчүүдийн барилдааны тооны нийлбэр $40 \cdot 15 = 600$ болно. Нөгөө талаас барилдаан бүр 2 удаа тоологдох тул нийт $\frac{600}{2} = 300$ барилдаан болно.

14.10.

$$(a, b, c, d) \in S_{AB} \times S_{BC} \times S_{BC} \times S_{AB}$$

байх дөрөвтүүдийн тоо нь декарт үржвэрийн чадал ба

$$|(a, b, c, d) \in S_{AB} \times S_{BC} \times S_{BC} \times S_{AB}| = |S_{AB}| \cdot |S_{BC}| \cdot |S_{BC}| \cdot |S_{AB}|$$

тул нийт замын тоо нь $4 \cdot 6 \cdot 6 \cdot 4 = 576$ байна.

14.11. Бид $\overline{abcd0}, \overline{abc0d}, \overline{ab0cd}, \overline{a0bcd}$ хэлбэрийн ялгаатай цифрүүд бүхий 5 оронтой тоог тоолно. Хувилбар тус бүрд a, b, c, d цифрүүдийг $A_9^4 = 4! \cdot C_9^4$ янзаар сонгох боломжтой тул нийт $4 \cdot 4! C_9^4$ ширхэг тоо байна.

14.12. ℓ_1 шулуун дээрээс 3 цэг сонгох боломжийн тоо C_4^3 , ℓ_2 шулуун дээрээс 3 цэг сонгох боломжийн тоо C_3^3 ба нийт 7 цэг байгаа тул

$$C_7^3 - C_4^3 - C_3^3 = 30$$

гурвалжин үүснэ.

14.13. 12 хүн хөзрөөс 3-ийг нь сонгох бүрт гурвуулаа хүн хөзөр байх нэг эгэл үзэгдэл гарах тул нийт C_{12}^3 эгэл үзэгдэл байна.

14.14. Бага ангийн 2 сурагчийг $C_8^2 = \frac{8 \cdot 7}{2} = 28$, дунд ангийн 2 сурагчийг $C_5^2 = \frac{5 \cdot 4}{2} = 10$ янзаар сонгоно. Иймд нийт боломжийн тоо $28 \cdot 10 = 280$ байна.

14.15. Нийт жагсаалын тоо $20!$ байх ба нийт жагсаалын яг хагаст нь Болд Амарын урд явах учир $\frac{20!}{2}$.

14.16. 24 болон өөр 3 цифрийг нийт $4!$ янзаар сэлгэх тул 24 гэж дараалж орсон $4 \cdot 4!$ ширхэг тоо болох ба 42 гэж дараалж орсон тоо мөн $4 \cdot 4!$ ширхэг байна. Иймд нийт $8 \cdot 4!$ ширхэг тоо үүсэх боломжтой.

14.17. 1 ба 3-ийн цифрүүд 13 гэж дараалж орсон нийт $8!$ тоо, 31 гэж дараалж орсон нь мөн адил $8!$ байна. Нийт тоонуудын тоо нь $9!$ тул бидний олох тоо

$$9! - 2 \cdot 8! = (9 - 2) \cdot 8! = 7 \cdot 8!$$

байна.

14.18. x_i нь i -р вагонд суусан сурагчдын тоо гэвэл

$$x_1 + x_2 + \dots + x_8 = 9$$

байна. Нөгөө талаас $x_1 + x_2 + \dots + x_8 = 9$ тэгшитгэлийн $(x_1, x_2, \dots, x_8)$, $x_i \in \{0\} \cup \mathbb{N}$ шийд бүрт i -р вагонд x_i сурагч суусан байх боломж харгалзах тул бидний олох тоо нь дээрх тэгшитгэлийн шийдийн тоо байна. Энэ нь 8-аас 9-өөр авсан давталттай хэсэглэлийн тоо тул

$$C_{(8)}^9 = C_{8+9-1}^9 = C_{16}^9 = \frac{16!}{7! \cdot 9!}$$

байна.

14.19. Дурын 4 цифрийг цор ганц аргаар үл буурах эрэмбээр байрлуулж болох ба эхний цифр нь 0-ээс ялгаатай тул 1-9 цифрүүдээс 4-ийг нь давталттайгаар сонгох тоо буюу

$$C_{(9)}^4 = C_{12}^4 = \frac{12 \cdot 11 \cdot 10 \cdot 9}{1 \cdot 2 \cdot 3 \cdot 4} = 495$$

байна.

14.20. Зуутын оронд 1 цифр бичигдсэн тоонууд нь 100, 101 гэх мэтчилэн 199 нийт 100 ширхэг тоо байна.

Аравтын оронд нь 1 цифр бичигдсэн 500-аас бага тоонууд нь 1а, 11а, 21а, 31а, 41а хэлбэртэй байх бөгөөд а-ийн оронд 0-9 цифрүүд байж болох нийт $5 \cdot 10 = 50$ ширхэг тоо байна.

Нэгжийн оронд нь 1 цифр бичигдсэн 500-аас бага тоонуудыг дээрхтэй төстэй аргаар тоолоод 50 ширхэг гэдгийг нь гаргах төвөгтэй биш. Иймд нийт $100 + 50 + 50 = 200$ ширхэг 1-ийн цифр ашиглана.

14.21. Эхлээд сүүлийн 2 оронтой тоо нь ямар тоонууд байж болохыг тооцъё. Эдгээр нь 12, 24, 32, 44, 52 байж болно. Эхний хоёр оронг тус бүр 5, 5 янзаар сонгож болох тул нийт $5 \cdot 5 = 25$ аргаар эхний 2 цифрийг сонгоно.

4 оронтой тоо бүрийг эхний 2 цифр ба сүүлийн хоёр цифрийн сонголтоор нэг утгатай бичиж болох тул зөвхөн 1, 2, 3, 4, 5 цифрүүдээр бичиж болох 4-д хуваагддаг 4 оронтой тоо нийт $25 \cdot 5 = 125$ ширхэг байна.

14.22. 1-р бодолт.

$$P(2, 1, 1, 1) = \frac{(2 + 1 + 1 + 1)!}{2! \cdot 1! \cdot 1! \cdot 1!} = \frac{5!}{2!} = 60$$

2-р бодолт. Таван байранд 5 үсэг байрлуулах бодлого гэж үзээд бодъё. Б үсгийг 5 янзаар байрлуулж болно. Хоёр О үсгийг үлдэх 4 байранд $C_4^2 = 6$ янзаар байрлуулж болно. Т үсгийг үлдэх 2 байрын аль нэгэнд буюу 2 янзаар, Г үсгийг сул үлдэх 1 байранд буюу 1 янзаар байрлуулна. Иймд $5 \cdot 6 \cdot 2 \cdot 1 = 60$ ялгаатай үг зохиож болно.

14.23.

$$P(3, 2, 1, 1, 1) = \frac{(3 + 2 + 1 + 1 + 1)!}{3! \cdot 2! \cdot 1! \cdot 1! \cdot 1!} = 3360$$

14.24. Ангийн 10 хүү, 10 охиноос 4 хүнтэй баг бүрдүүлэв.

$$1. \text{ Нийт боломжийн тоо нь } C_{20}^4 = \frac{20!}{16! \cdot 4!} = 4845.$$

$$2. \text{ Баг дан эрэгтэй сурагчаас бүрдсэн байх боломжийн тоо } C_{10}^4 = \frac{10!}{6! \cdot 4!} = 210.$$

$$3. \text{ Эрэгтэй, эмэгтэй сурагчид тус бүр 2 байх боломжийн тоо нь } C_{10}^2 \cdot C_{10}^2 = 45^2 \text{ тул багийн эрэгтэй ба эмэгтэй сурагчдын тоо тэнцүү байх магадлал}$$

$$\frac{45^2}{17 \cdot 3 \cdot 19 \cdot 5} = \frac{3 \cdot \cancel{15} \cdot 45}{17 \cdot \cancel{15} \cdot 19} = \frac{135}{323}$$

байна.

14.25.

$$1. \text{ Аливаа ялгаатай 3 элемент нь гурвалжны тэнцэтгэл бишийг хангах тул } C_5^3 = 10 \text{ ширхэг элдэв талт гурвалжин байна.}$$

$$2. \text{ 9, 9, 18-ээс ялгаатай } a, a, b \text{ хэлбэрийн 3 тоо сонгоход гурвалжин үүсэх тул } A_5^2 - 1 = 5 \cdot 4 - 1 = 19 \text{ ширхэг адил хажуут гурвалжин байна.}$$

$$3. \text{ Зөв гурвалжны тоо 5 тул нийт } 10 + 19 + 5 = 34 \text{ гурвалжин байна. Иймд сонгосон гурвалжин зөв гурвалжин байх магадлал } \frac{5}{34} \text{ байна.}$$

15. Магадлал, Статистик 2

15.1. Нар баруунаас гарах боломжгүй юм. Бусад үзэгдлүүдийн хувьд тодорхой магадлалтайгаар явагдах боломжтой үзэгдлүүд юм.

15.2. Шагай бүр 4 янзаар тусах тул нийт 4^5 янзаар, зоос бүр 2 янзаар тусах тул 2^3 янзаар тусах боломжтой. Иймд нийт $4^5 \cdot 2^3$ янзаар тусна.

15.3. Харилцан нийцгүй тул нийлбэр үзэгдлийн магадлал нь үзэгдэл тус бүрийн магадлалуудын нийлбэр буюу

$$0.1 + 0.2 + 0.3 + 0.3 = 0.9$$

байна.

15.4. 1-р хүн байг онохгүй байх магадлал $1 - 0.5 = 0.5$, 2-р хүн байг онохгүй байх магадлал $1 - 0.6 = 0.4$ ба бие биеэсээ хамаарахгүй тул хоёулаа оноогүй байх магадлал нь $0.5 \cdot 0.4 = 0.2$ байна.

15.5. $\{3; 1\}, \{4; 2\}, \dots, \{10; 8\}$ гэсэн нийт 8 хос байгаа. Нийт боломжит хосын тоо $C_{10}^2 = 45$ тул магадлал нь $\frac{8}{45}$ байна.

15.6. 2 гологдол бүтээгдэхүүнийг C_4^2 , 2 стандарт бүтээгдэхүүнийг C_{14}^2 янзаар сонгох тул 2 нь гологдол байх 4 бүтээгдэхүүнийг $C_4^2 C_{14}^2$ янзаар сонгоно. 4 бүтээгдэхүүнийг нийт C_{18}^4 янзаар сонгож болно. Бүх боломж ижил боломжтой гэж үзээд магадлал тооцвол $\frac{C_4^2 C_{14}^2}{C_{18}^4}$ байна.

15.7. Хар ба цагаан бөмбөг гарч ирэх боломжийн тоо $2 \cdot 3 = 6$. Нийт

$$2 + 3 + 4 + 5 = 14$$

бөмбөгнөөс хоёр бөмбөг авах боломжийн тоо $C_{14}^2 = \frac{14 \cdot 13}{2} = 91$. Иймд хар ба цагаан өнгөтэй 2 бөмбөг гарч ирэх магадлал $\frac{6}{91}$ байна.

15.8. Нийт хуваалтын тоо нь $\frac{C_{30}^{15}}{2}$. Эдгээрээс зөвхөн нэгд нь дан эрэгтэй сурагчтай хэсэг бий. Иймд нэг хэсэг нь дан эрэгтэй хүүхдээс бүрдсэн байх магадлал

$$\frac{1}{\frac{C_{30}^{15}}{2}} = \frac{2}{C_{30}^{15}}$$

байна.

15.9. $\frac{6 \cdot 3}{9 \cdot 8} = \frac{1}{4}$.

15.10. Бүх боломжийг жагсааж бичвэл хххх, хххо, ххох, хоxx, оххх, ххоо, хохо, хоох, оххо, охox, оохх, хооо, охоо, оохо, ооох, оооо байна. 2 хүү, 2 охинтой 6 боломж байгаа тул магадлал нь $\frac{6}{16} = \frac{3}{8}$ байна.

Жич: Туршилтаар p магадлалтай илэрдэг үзэгдэл n удаагийн туршилтаар яг k удаа илрэх магадлал $C_n^k p^k (1-p)^{n-k}$ байдаг. Үүнийг *Бернуллийн томьёо* гэдэг.


Манай бодлогын хувьд $p = \frac{1}{2}$ тул

$$C_4^2 \cdot \left(\frac{1}{2}\right)^2 \left(1 - \frac{1}{2}\right)^2 = \frac{3}{8}$$

гэж бодож болно.

15.11. Ядаж 2 талс нь будагтай кубийн тоо $8 + 12 \cdot 8 = 104$ тул магадлал нь $\frac{104}{1000} = \frac{13}{125}$ байна.

15.12.



Жижиг дугуйн талбай $S_1 = \pi \cdot \left(\frac{1}{3}\right)^2 = \frac{\pi}{9}$, том дугуйн талбай $S = \pi \cdot 1^2 = \pi$ байна. Том дугуйн бүх цэг ижил боломжтойгоор авагдана гэж үзээд геометр магадлал ашиглавал

$$P = \frac{S_1}{S} = \frac{\frac{\pi}{9}}{\pi} = \frac{1}{9}$$

15.13. Бодлогын нөхцөл ёсоор $P(G|A) = 0.2$, $P(G|B) = 0.6$, $P(G|C) = 1$ байна. Хэрэв X , Y , Z харгалзан 1, 2, 3-р сумаар оносон байх үзэгдэл бол

$$A = X\bar{Y}\bar{Z} + \bar{X}Y\bar{Z} + \bar{X}\bar{Y}Z$$

$$B = XY\bar{Z} + X\bar{Y}Z + \bar{X}YZ$$

$$C = XYZ$$

гэсэн харилцан нийцгүй үзэгдүүдийн нийлбэрт задарна. Иймд

$$\begin{aligned} P(A) &= P(X\bar{Y}\bar{Z}) + P(\bar{X}Y\bar{Z}) + P(\bar{X}\bar{Y}Z) \\ &= 0.4 \cdot 0.5 \cdot 0.3 + 0.6 \cdot 0.5 \cdot 0.3 + 0.6 \cdot 0.5 \cdot 0.7 = 0.36 \end{aligned}$$

$$\begin{aligned} P(B) &= P(XY\bar{Z}) + P(X\bar{Y}Z) + P(\bar{X}YZ) \\ &= 0.4 \cdot 0.5 \cdot 0.3 + 0.4 \cdot 0.5 \cdot 0.7 + 0.6 \cdot 0.5 \cdot 0.7 = 0.41 \end{aligned}$$

$$P(C) = 0.4 \cdot 0.5 \cdot 0.7 = 0.14$$

Иймд

$$P(G) = 0.2 \cdot 0.36 + 0.6 \cdot 0.41 + 1 \cdot 0.14 = 0.45$$

15.14. $P(A) = P(B) = \frac{1}{2}$, $P(X|A) = \frac{C_4^2}{C_{10}^2} = \frac{6}{45}$, $P(X|B) = \frac{C_4^2}{C_7^2} = \frac{6}{21}$ тул

$$\begin{aligned} P(X) &= P(XA) + P(XB) \\ &= P(X|A) \cdot P(A) + P(X|B) \cdot P(B) \\ &= \frac{2}{15} \cdot \frac{1}{2} + \frac{2}{7} \cdot \frac{1}{2} = \frac{22}{105} \end{aligned}$$

15.15. A, B, C, D, F -ээр сурагч тухайн дүнтэй суралцдаг байх үзэгдлийг, S -ээр спортоор хичээллэдэг байх үзэгдлийг тэмдэглэвэл Байесийн томьёо ёсоор:

$$\begin{aligned} P(B|S) &= \frac{P(B) \cdot P(S|B)}{P(A) \cdot P(S|A) + P(B) \cdot P(S|B) + \dots + P(F) \cdot P(S|F)} \\ &= \frac{\frac{20}{100} \cdot \frac{1}{8}}{\frac{10}{100} \cdot \frac{1}{10} + \frac{20}{100} \cdot \frac{1}{8} + \frac{30}{100} \cdot \frac{1}{4} + \frac{30}{100} \cdot \frac{1}{2} + \frac{10}{100} \cdot \frac{1}{2}} \\ &= \frac{20}{8 + 20 + 60 + 120 + 40} = \frac{20}{248} = \frac{5}{62} \end{aligned}$$

15.16.

$A = \{\text{таамгаар сонгон авсан эдлэл гологдол байх}\}$

$B_i = \{\text{энэ эдлэлийг } k\text{-р машин үйлдвэрлэсэн байх}\}$

үзэгдлүүд бол B_1, B_2, B_3 үзэгдлүүд нь хос хосоороо нийцгүй ба нийлээд A үзэгдлийг агуулна. Иймээс бүтэн магадлалын томьёо ашиглаж бодъё. Бодлогын нөхцөл ёсоор

$$P(B_1) = 0.30, P(B_2) = 0.25, P(B_3) = 0.45$$

ба

$$P(A|B_1) = 0.02, P(A|B_2) = 0.01, P(A|B_3) = 0.03$$

тул

$$\begin{aligned} P(A) &= P(B_1) \cdot P(A|B_1) + P(B_2) \cdot P(A|B_2) + P(B_3) \cdot P(A|B_3) \\ &= 0.30 \cdot 0.02 + 0.25 \cdot 0.01 + 0.45 \cdot 0.03 = 0.022 \end{aligned}$$

15.17.

$$\begin{aligned} E(X) &= \frac{1}{4} \cdot \frac{1}{2} + \frac{1}{4^2} \cdot \frac{1}{2^2} + \frac{1}{4^3} \cdot \frac{1}{2^3} + \dots + \frac{1}{4^n} \cdot \frac{1}{2^n} + \dots \\ &= \frac{1}{2^3} + \frac{1}{2^6} + \frac{1}{2^9} + \dots = \frac{\frac{1}{8}}{1 - \frac{1}{8}} = \frac{1}{7} \end{aligned}$$

15.18. $2 = 1 + 1, 3 = 2 + 1 = 1 + 2, 7 = 1 + 6 = 2 + 5 = \dots = 6 + 1, 8 = 2 + 6 = 3 + 5 = \dots = 6 + 2$ байна. Өөрөөр хэлбэл 2 нь 1 боломжтой, 3 нь 2 боломжтой, 7 нь 6 боломжтой, 8 нь 5 боломжтой байна. Иймд $n = 7$ байх магадлал хамгийн өндөр байна.

15.19.

$$E(X) = 0 \cdot 0.3 + 1 \cdot 0.5 + 2 \cdot 0.2 = 0.9$$


тул $(X - E(X))^2$ санамсаргүй хувьсагчийн тархалтын хууль нь

$(X - E(X))^2$	$(0 - 0.9)^2$	$(1 - 0.9)^2$	$(2 - 0.9)^2$	Σ
P	0.3	0.5	0.2	1

байна. Иймд дисперс нь

$$\text{Var}(X) = (-0.9)^2 \cdot 0.3 + 0.1^2 \cdot 0.5 + 1.1^2 \cdot 0.2 = 0.49$$

15.20. $A\left(\frac{\sqrt{2}}{2}, \frac{\sqrt{2}}{2}\right); B\left(-\frac{\sqrt{2}}{2}, \frac{\sqrt{2}}{2}\right); A'\left(-\frac{\sqrt{2}}{2}, -\frac{\sqrt{2}}{2}\right); B'\left(\frac{\sqrt{2}}{2}, -\frac{\sqrt{2}}{2}\right)$ гэе.



С цэг AB' богино нум дээр байх үед A өнцөг мохоо, $A'B$ богино нум дээр байх үед B өнцөг мохоо, AB богино нум дээр байх үед C өнцөг мохоо байна. Харин $A'B'$ богино нум дээр байх үед бүх өнцөг нь хурц байна. Иймд ABC гурвалжин хурц өнцөгт гурвалжин байх магадлал нь

$$\frac{\overset{\sim}{A'B'}}{2\pi} = \frac{\frac{\pi}{2}}{2\pi} = \frac{1}{4}$$

байна.

15.21. Гурван дугуй дүрсийг A_{12}^3 янзаар, гурван дөрвөлжин дүрсийг A_{12}^3 янзаар тус бүр будаж болох тул ялгаатай дүрслэлийн тоо $A_{12}^3 \cdot A_{12}^3 = (A_{12}^3)^2$ байна.

15.22.

1. Ядаж нэг удаа морь буух үзэгдэл нь нэг ч удаа морь буухгүй байх үзэгдлийн эсрэг үзэгдэл юм. Бернулийн томьёо ёсоор нэг ч удаа морь буухгүй байх үзэгдлийн магадлал нь

$$C_3^0 \left(\frac{1}{10}\right)^0 \left(1 - \frac{1}{10}\right)^{3-0} = \left(\frac{9}{10}\right)^3$$

тул үүний эсрэг үзэгдлийн магадлал

$$1 - \left(\frac{9}{10}\right)^3$$

байна.

2. Бернулийн томьёо ёсоор яг нэг удаа морь буух магадлал

$$C_3^1 \left(\frac{1}{10}\right)^1 \left(1 - \frac{1}{10}\right)^{3-1} = 0.243$$

3. Бернуллийн томъёо ёсоор яг хоёр удаа морь буух магадлал

$$C_3^2 \left(\frac{1}{10}\right)^2 \left(1 - \frac{1}{10}\right)^{3-2} = 0.027$$

15.23. Нийт хоёр оронтой тоонуудын тоо нь 90 байна.

1. 4 цифр агуулсан 2 оронтой тоонууд нь 14, 24, 34, 40, 41, ..., 49, 54, 64, 74, 84, 94 буюу нийт 18 ширхэг байх тул хоёр оронтой тоо 4 цифр агуулах магадлал $\frac{18}{90} = \frac{1}{5}$.
2. 4, 5 цифрүүд ороогүй нийт $7 \cdot 8 = 56$ тоо байна. (Аравтын орны цифр нь 0, 4, 5-аас бусад цифр, нэгжийн орны цифр нь 4, 5-аас ялгаатай). 4 ба 5 цифрүүдийн дор хаяж нэгийг нь агуулсан байх $90 - 56 = 34$ тоо байх тул магадлал нь $\frac{34}{90} = \frac{17}{45}$
3. Гуравт хуваагддаг нийт 30 ширхэг тоо байгаа. Магадлал нь $\frac{30}{90} = \frac{1}{3}$
4. 4 цифр агуулсан 3-д хуваагддаг тоонууд нь 24, 42, 45, 48, 54, 84 тул магадлал нь $\frac{6}{90} = \frac{1}{15}$

15.24. $a + b = 6$ байх боломжууд нь (1, 5), (2, 4), (3, 3), (4, 2), (5, 1); $a + b = 7$ байх боломжууд нь (1, 6), (2, 5), (3, 4), (4, 3), (5, 2), (6, 1); $a + b = 9$ байх боломжууд нь (3, 6), (4, 5), (5, 4), (6, 3) тул $\boxed{a} = 5$, $\boxed{b} = 6$, $\boxed{c} = 4$ байна.

I. Нийт (a, b) хосын тоо 36 ба үүнээс $a + b = 7$ байх нь 6 тул $P(7) = \frac{6}{36} = \frac{1}{6}$.

II. $3 \leq x \leq 7$ байх нийт $2 + 3 + 4 + 5 + 6 = 20$ боломж байгаа тул $P(3 \leq x \leq 7) = \frac{20}{36} = \frac{5}{9}$.

III. $x \leq 6$ байх нийт $1 + 2 + 3 + 4 + 5 = 15$ боломж байгаа тул магадлал нь $P(x \leq 6) = \frac{15}{36} = \frac{5}{12}$ байна.

15.25. Пифагорын теоремоор $h = \sqrt{13^2 - 5^2} = 12$ байна. Иймд конусын эзлэхүүн

$$V = \frac{1}{3} \cdot 5^2 \cdot 12\pi = 100\pi$$

байна. Конусын тэнхлэг огтлол нь 13, 13, 10 талбай адил хажуут гурвалжин тул $p = \frac{13 + 13 + 10}{2} = 18$, $S = \frac{10 \cdot 12}{2} = 60$ байна. Иймд $r = \frac{S}{p} = \frac{60}{18} = \frac{10}{3}$ ба багтсан бөмбөлгийн эзлэхүүн

$$V' = \frac{4}{3} \cdot r^3 \pi = \frac{4000}{81} \pi$$

тул санамсаргүйгээр сонгосон цэг бөмбөлөг дотор байх магадлал

$$\frac{V'}{V} = \frac{\frac{4000}{81} \pi}{100\pi} = \frac{40}{81}$$

байна.

16. Магадлал, статистик давтлага 2

16.1. Гурван тооны нийлбэр нь 17 байх 3 боломж бий:

$$5 + 6 + 6 = 6 + 5 + 6 = 6 + 6 + 5 = 17.$$

Нийт боломжийн тоо $6 \cdot 6 \cdot 6 = 6^3$. Бүгдээрээ ижил магадлалтай гэж үзэж болох тул бидний олох магадлал $\frac{3}{6^3} = \frac{1}{72}$ байна.

16.2. Хоёр тооны нийлбэр тэгш байхын тулд хоёулаа тэгш, эсвэл хоёулаа сондгой байна. Иймд сонгосон хоёр тоо тэгш байх боломжийн тоо

$$C_{25}^2 + C_{25}^2 = 2C_{25}^2 = A_{25}^2$$

ба нийт боломжийн тоо C_{50}^2 тул сонгосон хоёр тооны нийлбэр тэгш байх магадлал $\frac{A_{25}^2}{C_{50}^2}$ байна.

16.3. Ану, Баярыг нэг хүн гэж үзвэл Ану, Баяр гэж дараалж жагссан нийт $4!$ боломж бий. Үүнтэй адил Баяр, Ану гэж дараалж жагссан $4!$ боломж бий. Иймд Ану, Баяр хоёр зэрэгцэж зогссон $2 \cdot 4!$ боломж байна. Нийт $5!$ янзаар жагсах тул магадлал нь $\frac{2 \cdot 4!}{5!} = \frac{2}{5}$ байна.

16.4.

$$7!C_{10}^3 = 7! \cdot \frac{10!}{(10-7)! \cdot 7!} = \frac{10!}{(10-7)!} = A_{10}^7$$

16.5. 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 31, 41, 51, 61, 71, 81, 91 гэсэн 18 тоонд 1-ийн цифр оролцоно. Нийт $99 - 9 = 90$ ширхэг 2 оронтой тоо байх тул санамсаргүйгээр (бүх тоо ижил магадлалтай бичигдсэн үед) бичсэн 2 оронтой тоонд 1-ийн цифр оролцсон байх магадлал нь $\frac{18}{90} = 0.2$ байна.

2 оронтой тоо тохиолдолд 1-ийн цифр орсон тоонуудыг олоход тоочих аргыг хэрэглэхэд ямар нэг асуудал байхгүй байна. 3, 4 оронтой тоо үед яаж олох вэ? Үүний тулд нийт тоонуудын тооноос 1-ийн цифр ороогүйг нь хасаж олдог. Жишээ нь нийт гурван оронтоо тооны тоо $9 \cdot 10 \cdot 10 = 900$ (эхний цифр нь 0-ээс ялгаатай тул 9 боломжтой, бусад нь 10 боломжтой) бол 1-ийн цифр ороогүй гурван оронтой тооны тоо $8 \cdot 9 \cdot 9 = 648$ (эхний цифр нь 0 ба 1-ээс ялгаатай тул 9 боломжтой, бусад нь 1-ээс ялгаатай тул 9 боломжтой) байна. Иймд 1-ийн цифр орсон нь $900 - 648 = 252$ байна.

16.6. Ерөнхий гишүүн нь $T_{k+1} = C_8^k (3x)^k (-y)^{8-k}$ байна. Бидний олох гишүүд нь $k = 3$, $k = 5$ үед гарах тул


$$\begin{aligned} C_8^3 (3x)^3 (-y)^5 &= -27 C_8^3 x^3 y^5, \\ C_8^5 (3x)^5 (-y)^3 &= -243 C_8^5 x^5 y^3 \end{aligned}$$

болно. Коэффициентүүдийн нийлбэр нь

$$-27 C_8^3 - 243 C_8^5 = -27 C_8^3 - 243 C_8^3 = -270 C_8^3$$

16.7. n хүүхдийг нэг эгнээнд $n!$ янзаар жагсааж болох тул $29!$ байна.

16.8. Аливаа зангилааны цэг хүрэх замын тоо нь түүний зүүн ба доод зангилааны цэгүүд хүрэх замын тоонуудын нийлбэр тул



буюу нийт A цэгээс B цэгт 14 ялгаатай замаар, B цэгээс C цэгт 6 ялгаатай замаар очих тул A цэгээс C цэгт $14 \cdot 6 = 84$ ялгаатай замаар хүрнэ.

16.9. БОЛОЛЦОО үгэнд Б үсэг 1 удаа, О үсэг 4 удаа, Л үсэг 2 удаа, Ц үсэг 1 удаа орсон тул 1, 4, 2, 1 бүтэцтэй давталттай сэлгэмэлийн тоог олно.

$$P(1, 4, 2, 1) = \frac{(1 + 4 + 2 + 1)!}{1! \cdot 4! \cdot 2! \cdot 1!} = \frac{8!}{4! \cdot 2!} = \frac{5 \cdot 6 \cdot 7 \cdot 8}{2} = 840$$

16.10.

$$p(A \cap B) = p(A) \cdot p(B) = 0.8 \cdot 0.75 = 0.6 = \frac{3}{5}$$

16.11. Бүх боломжийг жагсааж бичвэл хххх, хххо, ххох, хохх, оххх, ххоо, хохо, хоох, оххо, охох, оохх, хооо, охоо, оохо, ооох, оооо байна. 3 хүү, 1 охинтой 4 боломж байгаа тул магадлал нь $\frac{4}{16} = \frac{1}{4}$ байна.

16.12. Зуутын оронд 6 цифр бичигдсэн тоо нь зөвхөн 600 байна.

Аравтын оронд нь 6 цифр бичигдсэн 600-аас бага тоонууд нь 6а, 16а, 26а, 36а, 46а, 56а хэлбэртэй байх бөгөөд а-ийн оронд 0-9 цифрүүд байж болох нийт $6 \cdot 10 = 60$ ширхэг тоо байна.

Нэгжийн оронд нь 6 цифр бичигдсэн 600-аас бага тоонуудыг дээрхтэй төстэй аргаар тооцоход 60 ширхэг байна. Иймд нийт $1 + 60 + 60 = 121$ ширхэг 6-ийн цифр ашиглана.

16.13. Зөв дарагдсан 3 тоог C_6^3 аргаар, буруу дарагдсан 3 тоог C_{30}^3 аргаар сонгож болох тул нийт $C_6^3 \cdot C_{30}^3$ янзаар яг 3 тоог зөв дарсан байж болно.

16.14. Бидний олох тоо $a + b + c + d = 20$ тэгшитгэлийн сөрөг биш бүхэл тоон шийдийн тоотой тэнцүү тул

$$C_{(4)}^{20} = \overline{C_4^{20}} = C_{20+4-1}^{20} = C_{23}^{20} = \frac{23!}{3! \cdot 20!} = 1771$$

16.15. Харилцан нийцгүй тул нийлбэр үзэгдлийн магадлал нь үзэгдэл тус бүрийн магадлалуудын нийлбэр буюу

$$0.1 + 0.2 + 0.3 = 0.6$$

байна.

16.16. Хоёр шоо нь ялгаатай биетүүд тул тэдгээр дээр тусах тоонууд нь эрэмбэлэгдсэн хос үүсгэнэ. I шоон дээр буусан нүдийг a , II шоон дээр буусан нүдийг b гэвэл үүнийг (a, b) хос гэж үзэж болно. Манай бодлогын хувьд $a + b = n$ тоо хамгийн олондоо хэдэн удаа тусч болох вэ гэсэн бодлого болж байна.

$n = 1$ байх боломж байхгүй. $n = 7$ байх нь

$$(1, 6); (2, 5); (3, 4); (4, 3); (5, 2); (5, 1)$$


гэсэн 6 боломжтой. $n = 8$ байх нь

$$(2, 6); (3, 5); (4, 4); (5, 3); (6, 2)$$

гэсэн 5 боломжтой ба $n = 10$ байх нь 3 боломжтой, $n = 11$ нь 2 боломжтой болохыг яг энэ байдлаар тооцож болно. Иймд хамгийн их магадлалтай нийлбэр нь 7 байна.

16.17. $x \leq y$ байх тохиолдолд хэрчмүүдийн урт x , $y - x$, $1 - y$ байна. Гурвалжны тэнцэтгэл бишээр

$$\begin{cases} x + (y - x) > 1 - y \\ x + (1 - y) > y - x \\ (1 - y) + (y - x) > x \end{cases} \Leftrightarrow \begin{cases} 0.5 < y \\ y < x + 0.5 \\ x < 0.5 \end{cases} \quad (1)$$



$y \leq x$ байх тохиолдолд хэрчмүүдийн урт y , $x - y$, $1 - x$ байна. Гурвалжны тэнцэтгэл бишээр

$$\begin{cases} y + (x - y) > 1 - x \\ y + (1 - x) > x - y \\ (1 - x) + (x - y) > y \end{cases} \Leftrightarrow \begin{cases} 0.5 < x \\ y < x - 0.5 \\ y < 0.5 \end{cases} \quad (2)$$

16.18.

$$E(X) = \sum_{k=1}^{\infty} \frac{1}{2^k} \cdot \frac{1}{2^k} = \sum_{k=1}^{\infty} \frac{1}{2^{2k}} = \frac{\frac{1}{4}}{1 - \frac{1}{4}} = \frac{1}{3}$$

$$E(X^2) = \sum_{k=1}^{\infty} \frac{1}{2^{2k}} \cdot \frac{1}{2^k} = \sum_{k=1}^{\infty} \frac{1}{2^{3k}} = \frac{\frac{1}{8}}{1 - \frac{1}{8}} = \frac{1}{7}$$

тул

$$Var(X) = E(X^2) - E^2(X) = \frac{1}{7} - \frac{1}{9} = \frac{2}{63}$$

16.19.

$$\begin{aligned}
 E(X) &= 1 \cdot \frac{1}{S} + 2 \cdot \frac{2}{S} + \dots + 2017 \cdot \frac{2017}{S} \\
 &= \frac{1^2 + 2^2 + \dots + 2017^2}{1 + 2 + \dots + 2017} \\
 &= \frac{2017 \cdot (2017 + 1) (2 \cdot 2017 + 1)}{6} \quad \leftarrow 1^2 + 2^2 + \dots + n^2 = \frac{n(n+1)(2n+1)}{6} \\
 &= \frac{2017 \cdot (2017 + 1) \cdot 2}{6} \\
 &= \frac{2 \cdot 2017 + 1}{3} = 1345
 \end{aligned}$$

16.20. 1-ээс 100 хүртэлх тоон дотор 3-т хуваахад 1 үлдэгдэл өгдөг тоо 34 ширхэг, 3-т хуваахад 0 эсвэл 2 үлдэгдэл өгдөг тоо тус бүр 33 ширхэг байна. Иймд нийлбэр нь 3-т хуваагдах 3 ялгаатай тоог

$$C_{34}^3 + C_{33}^3 + C_{33}^3 + C_{34}^1 C_{33}^1 C_{33}^1 = 53922$$

янзаар сонгож болно.

16.21. $A = \{ \{k, p\} | 1 \leq k < p \leq 12 \}$ үзэгдэл байг. Тэгвэл


болно. Иймд $p(A) = \frac{C_{12}^2}{C_{20}^2}$ ба $p(B) = \frac{C_{12}^1 \cdot C_8^1}{C_{20}^2}$ байна, учир нь $1 \leq k \leq 12$, $13 \leq p \leq 20$ үед л B үзэгдэл явагдана.

16.22.

1. Тус бүр 5 ($1 \leq a_i \leq 5$) боломжтой тул $5 \cdot 5 \cdot 5 = 125$ байна.
2. Тус бүр 4 ($1 \leq a_i \leq 4$) боломжтой тул $4 \cdot 4 \cdot 4 = 64$ байна.
3. Хамгийн их нь 5 байх боломжийн тоо өмнөх 2-ийн ялгавар буюу $125 - 64 = 61$ байна.

Нийт 216 боломжтой тул хамгийн их нь 5 байх магадлал $\frac{61}{216}$ байна.

16.23.



$a^2 - 4b < 0$ байх дүрсийн талбай нь $S = \int_0^1 \frac{a^2}{4} da$ интегралаар бодогдох тул

$$S = \left. \frac{a^3}{12} \right|_0^1 = \frac{1^3}{12} - \frac{0^3}{12} = \frac{1}{12} \text{ болно. Энэ хэсгийн талбай нь нэгж квадратын талбайн } \frac{1}{12} \text{ хэсэг}$$

тул квадратаас санамсаргүйгээр сонгосон цэг $a^2 - 4b < 0$ нөхцөлийг хангаж байх магадлал нь $\frac{1}{12}$ байна.

16.24.

1. Улаан өнгийн төгсгөлтэй хэрчмийн тоо $C_5^2 = 10$, хөх өнгийн төгсгөлтэй $C_2^2 = 1$, ногоон өнгийн төгсгөлтэй C_3^2 нийт $10 + 1 + 3 = 14$ ижил өнгийн төгсгөлтэй хэрчим байна.
2. Улаан оройг 5 янзаар, хөх оройг 2 янзаар, ногоон оройг 3 янзаар сонгох тул $5 \cdot 2 \cdot 3 = 30$.
3. Нийт гурвалжны тоо $C_{10}^3 = 120$. Улаан гурвалжны тоо $C_5^3 = 10$, хөх гурвалжин байхгүй, ногоон гурвалжин нэг тул ижил өнгийн гурвалжин нийт 11 байна. Санамсаргүйгээр авсан гурвалжин нэг өнгийн байх магадлал нь $\frac{11}{120}$.

16.25. Нийт 2 карт сонгох боломжийн тоо $C_{13}^2 = \frac{13 \cdot 12}{2} = 78$ байна.

1. 1 орсон 2 карт сонгох боломжууд нь $\{1; 2\}, \{1; 3\}, \dots, \{1; 12\}$ нь гэсэн 12 боломж бий. Иймд магадлал нь $\frac{12}{C_{13}^2} = \frac{12}{78} = \frac{2}{13}$ байна.
2. 1 дугаартай карт ба тэгш дугаартай карт байх боломжууд нь $\{1; 2\}, \{1; 4\}, \dots, \{1; 12\}$ нь гэсэн 6 боломж бий. Иймд магадлал нь $\frac{6}{C_{13}^2} = \frac{6}{78} = \frac{1}{13}$ байна.
3. Тэгш дугаартай картууд нь 2, 4, 6, 8, 10, 12 тул 2-ийг нь сонгох боломжийн тоо $C_6^2 = 15$ байна. Иймд магадлал нь $\frac{15}{78} = \frac{5}{26}$ байна.

17. Комплекс тоо 2

17.1.

